



УЛСЫН МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

(Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)

ЗОРИЛТ 1. МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ОНОШИЛОГОО, ТАНДАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /үзүүлэлт/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Биелэлт (2024 оны жилийн эцэс)	Санхүүгийн эх үүсвэр (сая төг), хугацаа	ТЕЗ-ын өгөх үнэлгээ
<i>Ерөнхий чиг үүргийн нэр:</i> Мал,амьтны гоц халдварт, халдварт өвчин, хордлогыг оношлох, тандах, мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдлын баталгаажуулалт хийх						
<i>Үндсэн чиг үүргийн нэр:</i> Монгол орны нутаг дэвсгэр дээрх мал, амьтны гоц халдварт өвчнийг оношлох, онош баталгаажуулах						
1. Засгийн газрын 2008 оны 305 дугаар тогтоолын 1.4 дэх заалт, 2. МАЭМТ хууль 3. “УМЭАЦТЛ” УТҮГ-ын дүрэмд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд 4. МУЗГҮАХ 5. ЗХГА-МЭЕГ-ын бодлого, чиглэл	Арга зүй, стандарт шинэчлэх, шинээр нэвтрүүлэх	Шинэчилсэн тоо, шинээр нэвтрүүлсэн тоо	Арга зүй нь цомгийн зааварт үндэслэн өөрчлөлт орох,	Тендерээр хүлээн авсан шинэ оношлуур, урвалжид тохируулан стандарт ажлын заавар боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Үүнд: 1.Мал амьтны эцэг эх тодорхойлох шинжилгээг нуклеотидийн дараалал тогтоох аргын САЗ 2. Minion Nanopore багаж ашиглаж бактери болон вирусийн геномын мэдээлэл тодорхойлох САЗ тус тус боловсруулсан.	Улсын төсөв, I-IV улирал	
	Дээд байгууллагаас ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлт	-Хэрэгжилтийн үнэлгээний дундаж, хувь -Хугацаандаа гүйцэтгэсэн байдал, хоцорсон хоног	Дээд байгууллагаас ирүүлсэн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь хийж, хариу мэдээлэх.	Дээд байгууллагаас ирүүлсэн үүрэг даалгавар, тандалтуудын үйл явж, тайлан тооцоог заасан хугацаанд нь гүйцэтгэн мэдээллэж байна.		
	Шуурхай дуудлага үйлчилгээ үзүүлэх	Шуурхай дуудлагаар ажилласан, хоног	Шаардлагатай дуудлагаар оношлогоо, шинжилгээний үйлчилгээ орон нутагт шуурхай үзүүлэх	Шуурхай дуудлагаар газар дээр нь очиж, орон нутагт хурдан, найдвартай оношлох зорилгоор Ямааны гогдрон өвчний шинжилгээг Дорноговь аймгийн Хатанбулаг, Хөвсгөл сумуудад 10-р сарын 17-19-ний өдрүүдэд Ц. Батдолгор эмч, БММ өвчний тархалтын хүрээ тогтоох ажлаар Өвөрхангай аймгийн 9 сумуудад 9-р сарын 04-13-ний хооронд, БММ өвчний онош баталгаажуулах, дээж цуглуулах		

				зорилгоор Нарийнтгээл суманд 8-р сарын 16-18-ний хооронд Ц. Амартүвшин эмч, Хонины цэцэг өвчний дуудлагаар Төв аймгийн Баянтал сум, Дундговь аймгийн нар Өлзийт суманд, адууны ям өвчний дуудлагаар Төв аймгийн Сэргэлэн суманд Б. Очирбат эмч нар тус тус ажилласан.		
1. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 33.1.2, 33.1.2.2, 33.1.2.3 заалт, УИХ-ын 23 дугаар тогтоол”Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 3.3.1.4, 3.3.2.4, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.8,3 2. “УМЭАЦТЛ” УТҮГ-ын дүрэмд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын Засгийн Газрын 2018 оны 12 дугаар тогтоол, Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн 2.2.6,3.6, 3.9заалт	Тандалт шинжилгээний ажлуудын гүйцэтгэл	Тайлангийн тоо	2	2		
		Хугацаандаа тайлагнасан, хувь	Хугацаандаа тайлагнасан - 100%	Хугацаандаа тайлагнах - 100%,		
	Вакцины дараах тандалт шинжилгээ	Тайлангийн тоо	Шүлхий болон бог малын мялзан өвчнөөс сэргийлэх вакцины мониторинг жил бүр хийгдэж байна.	Улсын хэмжээнд Малын гоц халдварт шүлхий өвчний вакцинжуулалтын дараах мониторинг хийх, дархлааны түвшинг тогтоох тандалтын удирдамж боловсруулан батлуулсан ба 21 аймаг, нийслэлийн нийт 365 сум, дүүргийн 3024 үхрээс дээж цуглуулж шүлхийн вирусийн бүтцийн уургийн О болон А хэвшлийн эсрэг бие илрүүлэх ЕЛИЗА урвалын шинжилгээг ГХӨӨТЛ-т хийж гүйцэтгэн, үр дүнг нэгтгэн, ДАТА боловсруулалт хийж аймгуудын дүнг нэгтгэхэд О хэвшлээр 2708 дээж эерэг буюу 89.6%, А хэвшлээр 2248 дээж эерэг буюу (74.34%) тус тус үр дүн үзүүлэв. БММ өвчний вакцины дараах мониторингийн ажлын төсөв батлагдах ажил удааширсантай холбоотойгоор тандалтын удирдамж, гэрээ одоо батлагдаж, тандалтын ажил эхэлж байна. БММӨ-ий 2024 оны төлөвлөгөөт вакцинжуулалт ажил 10 сард эхэлсэн бөгөөд вакцинжуулалтын ажил удаашралтай явагдсан. Мөн тандалтад шаардлагатай төсөв батлагдах ажил удааширсан. МЭЕГ даргын тушаалаар тандалтын удирдамж батлагдах шатандаа явж байна.Ажил гүйцэтгэх гэрээг хийж албажуулж хүргүүлсэн. Тандалтын ажил 12 сарын эхний 5 гэхэд эхэлж хурдан		

				шуурхай гүйцэтгэж холбогдох тайланг хүргүүлнэ.		
	Халдвар илрүүлэх тандалтын шинжилгээ	Тайлангийн тоо -9	Жил бүр тандалтын ажлыг зохион байгуулан, үр дүнг танилцуулдаг.	Дараах 9 тандалтын удирдамж, төлөвлөгөөг боловсруулж, батлуулж, гүйцэтгэсэн. Үүнд: -Шүлхий өвчний халдвар илрүүлэх, тархалтын хүрээг тодорхойлох тандалт: Малын гоц халдварт шүлхий өвчний халдварыг тандах, халдварын түвшин болон тархалтын цар хүрээг тогтоох зорилгоор тандалтыг батлагдсан удирдамж арга зүйн дагуу 22 аймаг, нийслэлтэй хамтран зохион байгуулж 10080 дээж цуглуулан бүх аймгийн лабораториудад ББУ илрүүлэх ЕЛИЗА урвалын цомгийг илгээж, аймаг бүрээр шинжилгээг хийлгэн эерэг дүн үзүүлсэн сорьцыг ГХӨТЛ-д баталгаажуулах зорилгоор хүлээн авч, давтан шинжилгээг хийж, үр дүнг нэгтгэн ДАТА боловсруулалт хийхэд тандалтад хамрагдсан 4 айл тутмын нэг нь эерэг дүн үзүүлэв. Тандалтын дүнгээс харахад 2024 онд мал, амьтны түвшинд тархалтын хувь буюу халдварлалтын түвшин (хот айл, улсын хэмжээнд) 2023 онд 126 дээж буюу 22% - тай байсан бол 2024 онд 94 хот айл буюу 15% тай гарч 7%-аар буурсан байна. -БММ өвчний халдвар илрүүлэх, тархалтын хүрээг тодорхойлох тандалт: БММӨ-ний вирусийн эсрэг бие илрүүлэх ЕЛИЗА урвалын шинжилгээгээр нийт 21 аймаг, нийслэлийн 630 хот айлын 7560 хонь, ямаа шинжлэгдсэн ба үүнээс нийт 2909 буюу 38.4% -д нь эерэг үр дүн үзүүлэв. Энэхүү үр дүнг дараах зорилтуудад хувааж дүнг гаргав.Үүнд:		

				- Зорилт 1. Зөвхөн төл дархлаажуулсан 4 аймгийн нийт n=1440 сорьцоос 772 сорьц эерэг үр дүн үзүүлсэн бөгөөд шинжлэгдсэн сорьцын 54%-д эсрэгбием илэрсэн - Зорилт 2. Ямаа болон төл дархлаажуулсан 10 аймгийн n=3240 сорьцоос 2006 сорьц эерэг үр дүн үзүүлсэн ба шинжлэгдсэн нийт сорьцын 62%-д эсрэгбием илэрсэн - Зорилт 3. Сүүлийн 3-аас доошгүй жилийн хугацаанд огт вакцин тариагүй 8 аймгийн n=2880 сорьцоос 131 сорьц сорьц эерэг үр дүн үзүүлсэн. Энэхүү эерэг 131 сорьц нь илрүүлэх болон баталгаажуулах шатны ЕЛИЗА урвалын шинжилгээгээр ижил үр дүн үзүүлсэн. Баянхонгор аймгийн Бууцагаан сумын хоорондоо алслагдмал 2 малчин өрхийн нэг нэг сорьц байв. Асуумж судалгаанаас харахад тухайн малчин өрхүүдэд БММӨ-ний ямар нэгэн эмнэлзүйн шинж тэмдэг халдварт өвчний шинж тэмдэг байгаагүй,шилжилт хөдөлгөөн хийгдээгүй гэсэн өгөгдөлтэй боловч аймгийн МЭГ-аас тодруулахад 2024 оны 3 сард тухайн малчин өрхүүдэд БНХАУ-ын Синофарм компанийн бог малын мялзан, хонь, ямааны цэцгээс сэргийлэх хос цэнт вакцин таригдсан байв. Түүнчлэн дархлаажуулалтын төлөвлөгөө ёсоор БММ-ийн вакцин тариагүй байсан Сүхбаатар аймгийн Онгон, Дарьганга сумдад 2023 оны 7-8 дугаар сард БММ өвчин оношлогдсон ба яаралтай үеийн вакцинжуулалтад хонь, ямааг хамруулснаар тандалтанд хамрагдсан 9 сумын 21 малчин өрхийн 129 мал (асуумж		
--	--	--	--	--	--	--

				судалгаагаар сорьц авсан бүх мал 12-24 сартай гэж тэмдэглэсэн) эерэг үр дүн үзүүлэв. -Гахайд зонхилон тохиолдох халдварт өвчний тандалт: Тандалтад хамрагдсан нийт ийлдэсний 370 сорьцоос гахайн парвовирусийн эсрэгбием 105 буюу 28%, микоплазм өвчний вирусийн эсрэгбием 60 буюу 16%, цирковирүс өвчний вирусийн эсрэгбием 68 буюу 18%, гахайн томуу өвчний вирусийн эсрэгбием 96 буюу 26%-д эерэг дүн тус тус үзүүлэв. Аж ахуй эрхлэгч иргэд халдварыг мэдээгүй, халдварын талаар мэдсэн боловч мал эмнэлгийн байгууллагад мэдэгдээгүй, халдварын талаар мэдэж нэгжийн мал эмнэлэгт мэдэгдсэн боловч сумын мал эмнэлэг цаашдын арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байж магадгүй байгаа нь цаашид халдварыг тараах өндөр эрсдэлтэй байна. Лабораторийн шинжилгээнд үндэслэн гахайн үржил-амьсгалын замын хам шинж, гахайн сонгомол мялзан, томуу, коронавирус, шүлхий, бруцеллөз зэрэг өвчнөөр тандалтад хамрагдсан аймаг, нийслэлийн гахайн сүрэг өмнөх жилүүдийн тандалтын үр дүнтэй адил халдваргүй тайван, эрсдэл багатай байна. -Тэжээвэр болон зэрлэг шувууны өвчнийг оношлох, тандах шинжилгээ: Тус тандалтын хүрээнд 2 аймгийн 5 сумын 18 өрхөөс ийлдэсний 100, арчдасны 200 сорьц цуглуулав. Аж ахуйн нэгж, өрх айл бүрээс тандалтын ажлын удирдамжид заасан асуумжийн дагуу асуумж аван вакцинд хамрагдсан эсэх талаар асууж тодруулан ажиллав. Тандалт шинжилгээгээр Дархан-Уул аймгийн 4 сумаас ирүүлсэн 50 тахианы ийлдэсний 4		
--	--	--	--	---	--	--

			нь буюу 8% (4 тахиа шувууны томуугийн вакцин таригдсан) шувууны томуу өвчний вирусийн эсрэг бием илэрсэн. Орхон аймгийн Баян-өндөр сумаас ирүүлсэн 50 тахианы ийлдсэнд шувууны томуу өвчний вирусийн эсрэгбием илрээгүй. Бц-ПГУ-ын шинжилгээгээр мөгөөрсөн хоолойн арчдас-100, сүвний арчдас-100 нийт 200 ширхэг сорьцод шувууны томуу өвчин үүсгэгчийн генийн өвөрмөц хэсэг илрээгүй. -Шинэ болон дахин сэргэж буй өвчний эрт илрүүлэх тандалт: Уг тандалтаар Сэлэнгэ Дархан-Уул, Булган аймгийн 19 сумын цуглуулсан хонь-86, ямаа-86, адуу-120, үхэр-58 нийт 350 ийлдэсний сорьцод Хэл хөхрөх өвчний эсрэгбием 116(50.4%)-д (адууны сорьцод хийгээгүй), Баруун нил 21(6%)-д, Хачигт энцефалит 19(6%)-д сорьцод эерэг дүн тус тус үзүүлэв. Япон энцефалит, Маеди-висна/Ямааны үе тархины үрэвсэл, Ку халуурал, Хил орчмын өвчнөөр эсрэгбием илрээгүй сөрөг дүн үзүүлэв. -Нуур, голын загасанд зарим халдварт өвчин илрүүлэх тандалт: энэхүү тандалтыг нуур голын ус хөлдөх үеэр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. -Адууны халдварт цус багадах болон адууны африк мялзан өвчин (Адууны 4 өвчний тандалтын хүрээнд)-ий тандалт: Адууны халдварт цус багадах өвчин (АХЦБӨ)-ий нэвчин тунадасжуулах урвалын шинжилгээгээр Сэлэнгэ аймгийн Жавхлант, Орхонтуул сумдаас ирүүлсэн адууны хоёр сорьцод эерэг дүн илрэв. Энэхүү тандалтаар цуглуулсан дээжид тус		
--	--	--	---	--	--

				аймагт өвчний тархалтын түвшин 1.17% байгааг тогтоолоо. Харин улсын хэмжээнд уг өвчний нийт тархалтын түвшин 0.05% байгаа нь халдварлалтын түвшин бага байна. Адууны африкийн мялзан өвчний ФХЭБУ-ын шинжилгээгээр нийт 3380 сорьцод урвал тавихад бүх сорьц сөрөг дүнтэй гарсан нь Монгол улсад энэхүү өвчний халдваргүйг харуулж байна. -Зэрлэг амьтанд зарим халдварт өвчнийг илрүүлэх тандалт, судалгаа; Булган аймгийн Булган сумаас идэвхгүй тандалтын хүрээнд цуглуулсан зэрлэг гахайн 3 ширхэг эмгэгт эдийн сорьцод гахайн африкийн мялзан өвчний шинжилгээ хийхэд сөрөг дүн үзүүлэв. Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумаас тандалтаар ирүүлсэн зээрийн 5 эмгэгт эдийн дээжинд шүлхий өвчний вирусийн генийн өвөрмөц хэсэг илрүүлэх БХ-ПГУ-аар шинжилгээ хийхэд 5 дээж эерэг дүн үзүүлэв. -Каприпокс (үхрийн арьс товруутах, хонь, ямааны цэцэг) үүсгэгчийн халдварын тандалт: Хонины цэцэг өвчний эсрэгбием илрүүлэх ЕЛИЗА урвалын шинжилгээгээр 22 аймгийн 630 хот айлын 3780 хонины ийлдсийн сорьц шинжлэхэд үүнээс 14 аймгийн 64 сумын 131 малчин өрхийн 424 дээж эерэг үр дүн үзүүлэв. Хонины цэцэг өвчний хувьд Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Улаанбаатар, Хэнтий аймгуудад хонины цэцэг өвчний тархалт өндөр байгааг харуулсан. Иймд энэхүү үр дүнг хонины цэцэг өвчний эсрэг тарьсан вакцинжуулалтын үр дүнтэй холбож тайлбарлаж болох юм. Үхрийн арьс		
--	--	--	--	--	--	--

				товруутах өвчний хувьд 7 (Дорнод, Төв, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь, Улаанбаатар, Говьсүмбэр) аймгийн 30 үхрийн ийлдэсний сорьц эерэг дүн үзүүлэв.		
		Хугацаандаа тайлагнасан, хувь	Хугацаандаа тайлагнасан - 100%	Хугацаандаа тайлагнах - 100%		
Ерөнхий чиг үүргийн нэр: Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн чанарын удирдлагын тогтолцоог сайжруулах						
Үндсэн чиг үүргийн нэр: Мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, сургах						
МАЭМТ хууль ЗХГА-МЭЕГ-ын бодлого, чиглэл Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн журам	Оношлогооны шинэ арга, технологи нэвтрүүлэх	Мал, амьтны өвчний нөхцөл байдлыг харгалзан үзлэг, шинжилгээ хийж үр дүнг өгөх	2023 оны жилийн эцсийн байдлаар ДМАЭМБ-ын зөвлөсөн үндсэн болон орлуулах аргууд болох ЕЛИЗА, ПГУ, Бодит цагийн-ПГУ, ген секвинсинг болон бусад аргуудаар оношлов.	Адууны томуу, бог малын мялзан, гахайн африк мялзан, томуу, хонины цэцэг, хорт салст халуурал, шувууны ньюкастл өвчин, шүлхий, шөвөг яр, аденоматоз, адууны вирусын артерит, адууны ринопневмони, гахайн сонгомол мялзан, гахайн үржил амьсгалын замын хам шинж өвчин, нохойн гударга, галзуу, адууны халдварт цус багадах, үхрийн арьс товруутах, ямааны цэцэг өвчний оношилгоог ЕЛИЗА, ПГУ, бодит цагийн-ПГУ, ген секвинсингийн аргын аль нэг эсвэл хосолсон байдлаар шинжилгээг гүйцэтгэв.	Улсын төсөв, жилд	
	Лабораторийн бэлэн байдал хангалт	Шинжилгээнд ирүүлсэн сорьцын шинжилгээний гүйцэтгэл, хувь	Сорьцонд түргэн, шуурхай мадаггүй оношилгоо, шинжилгээ хийсэн. 100%	Гоц халдварт өвчний оношилгоо тандалтын лабораторид нийт 2008 дээж хүлээн авсан ба 19 үзүүлэлтээр шинжилгээг гүйцэтгэсэн. Шинжилгээнд хамрагдах зорилгоор дээж нь оношлох 1032, онош баталгаажуулах 197, тандалт 15, дотоод хяналт 55, импорт 584, магадлах 6, экспорт 119 тус тус байна. БММ, ГАМ, хонины цэцэг, шөвөг яр болон шүлхий өвчний үүсгэгчийн генийн хэсэг, галзуу өвчний эсрэгтөрөгч, адууны вирусын артерит, адууны ринопневмони, адууны томуу, адууны халдварт цус багадах өвчин, гудрага, томуу, БММ, хонины цэцэг болон шүлхий өвчний эсрэгбием тус тус илэрсэн байна.		

	Итгэмжлэл, чанарын гарын авлага, нэгдсэн арга зүйгээр хангах	Орон нутгийн эмч нарт сургалт, арга зүйн зөвлөмж өгөх	Шинжилгээний арга зүй эзэмшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан.	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн санхүүжилтээр сүлжээ лабораторийн хүрээнд ажлын байрны сургалт зохион байгуулагдаж байна.		
	Сүлжээ лабораторийн мэргэжилтний чадавхжуулалт (журмын 5.1.1)	Дадлагажуулсан шинжээч, тоо	Мал эмнэлгийн сүлжээ лабораториудыг арга зүйн удирдлагаар хангаж 2023 онд Дадлагажуулсан эмчийн тоо –	Сэлэнгэ аймгийн лабораторийн 2 шинжлэгч эмч, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийн 3 шинжлэгч эмч нарт ийлдэс судлал, молекул биологийн шинжилгээний арга зүй эзэмшүүлсэн.		
МАЭМТ хууль ЗХГА-МЭЕГ-ын бодлого, чиглэл Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн журам	Оношлуур, урвалжийн МУ-д хэрэглэх баталгаажуулалт, дүгнэлт зөвлөмж /сүлжээ лаб-д ашиглах/	Оношлуур, урвалж, тоо (журмын 5.2.13)	Оношлуур, эм урвалжийн захиалгыг төлөвлөн, холбогдох байгууллагад хүргүүлэх, тендерийн үнэлгээний үйл ажиллагаанд оролцох, барааг хүлээн авч, зарцуулалтыг тайлагнасан.	Гоц халдварт өвчний оношилгоонд шаардлагатай урвалж оношлуурын захиалгыг нэгтгэн ерөнхий захиалгад оруулав. Мөн тандалтын ажлын хүрээнд хэрэглэгдэх оношлуур урвалжийн техникийн тодорхойлолт бэлтгэн боловсруулав.		
	Оношилгоо, шинжилгээнд зарцуулсан хугацааны стандарт мөрдөлт (журмын 5.1.3)	Дундаж хоног Гоц халдварт, Халдварт, Халдваргүй Шимэгчтэх,	Тус лабораторид нийт 5051 дээж хүлээн авч, шинжилгээ хийсэн.	2024 оны эхний хагас жилийн байдлаар 2008 дээж хүлээн авсан ба 19 үзүүлэлтээр шинжилгээг гүйцэтгэсэн. Шинжилгээний хариуг тухай бүр системд оруулан хянуулж, батлуулсан.		
	Баталгаажуулах шинжилгээний гүйцэтгэл	Ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн шинжилгээний гүйцэтгэл, хувь	ДМАЭМБ-аас зөвлөсөн арга зүйн дагуу баталгаажуулах шинжилгээг цаг тухай бүрт хийж гүйцэтгэх	-Өвөрхангай аймгийн Баянгол, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумаас сорьцыг хүлээн авч, хонины цэцэг өвчний оношийг баталгаажуулав. - Оношийг баталгаажуулах зорилгоор сорьцыг гадаадын лабораторид илгээж, шинжлүүлэв. Үүнд: + Дундговь аймгийн Өлзийт, Дорноговь аймгийн Даланжаргалан сумаас ирсэн сорьцонд шинжилгээ хийж бог малын мялзан өвчнийг оношилсон.		

				+ Оношийг баталгаажуулах зорилгоор Англи улсын шүлхий өвчний лавлагаа лаборатори, Пирбрайтын хүрээлэн рүү сорьцыг илгээж баталгаажуулсан. +Хэнтий аймгийн Хэрлэн, Булган аймгийн Булган, Архангай аймгийн Эрдэнэбулган, Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Орхон аймгийн Баян-Өндөр сумаас ирсэн сорьцонд шинжилгээ хийж гахайн африк мялзан өвчин оношилсон. Оношийг баталгаажуулах зорилгоор Австрийн Вена хот дахь олон улсын цөмийн энергийн агентлагийн Мал амьтны эрүүл мэндийн лабораторид сорьцыг илгээж баталгаажуулсан.		
		Баталгаажуулах шинжилгээнд ашигласан ахисан түвшний арга зүй, хувь (журмын 3.8)	Дотоодын баталгаажуулах шинжилгээнд шинэ арга зүйг хэрэглэх	Тендерээр хүлээн авсан оношлуур, цомгийн зааврыг стандарт ажлын заавар болгон ашиглаж байна.		
		Баталгаажуулсан үр дүнгийн зөрүү, хувь (журмын 3.9)	Малын гоц халдварт 4 өвчний ийлдэс судлалын 2022 оны тандалтын хүрээнд Шүлхий, БММ өвчний ийлдэсний үр дүн батлагдсан.	Энэ онд хийгдэх тандалт болон мониторингийн шинжилгээний үр дүнг орон нутгаас хүлээн авч, эерэг гарсан сорьцонд баталгаажуулах шинжилгээ хийгдэнэ.		
	Ур чадварын сорил (журмын 3.7)	Жилд хамрагдах тоо	Гадаад дотоодын болон лаборатори хоорондын харьцуулалтын ур чадварын сорилд оролцож, шинжилгээний үнэн зөв найдвартай байдал үнэлэгдэнэ.	Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам, MNS ISO/IES 17025:2018 стандартын шаардлагын хүрээнд УМЭАЦТЛ-оос 21 аймаг болон нийслэлийн мал эмнэлгийн лабораториудад гоц халдварт 4 төрлийн өвчнийг молекул биологийн аргаар оношлох сорилыг хүргүүлэн, үр дүнг нэгтгэв. Уг сорилд Баян-Өлгий аймаг оролцоогүй, бусад бүх аймаг оролцож 50-100% үнэлгээ авав. Мөн гаргасан алдааг		

				эмч нарт зааж, залруулж ажиллаа. Ховд болон Увс аймгууд 94-100%-ийн үр дүнтэй, амжилттай оролцсон.		
	Лаборатори хоорондын харьцуулалт (журмын 3.6) Онош баталгаажуулалт (журмын 5.1.10)	Жилд хамрагдах тоо Лавлагаа лабораториор онош батлагдсан хувь	Өнгөрсөн онд хамрагдсан ОУ-н ур чадварын сорил, лавлагаа лабораторид илгээсэн сорьцын шинжилгээний хариу тус тус 100 хувь байв.	Дээр дурдсанаар гахайн африк мялзан болон бог малын мялзан өвчний оношийг баталгаажуулах зорилгоор гадаадын лабораторид сорьц илгээсэн. Онош 100 % батлагдав (гахайн африк мялзан, бог малын мялзан).		
Ерөнхий чиг үүргийн нэр: Байгууллагын дотоод ажлын хүрээнд						
Үндсэн чиг үүргийн нэр: Оношлогоо, шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэх, шинэ санаачлага гаргах						
Зорилт	Өгүүлэл, гадаад хэл дээр	Оношилгоо шинжилгээ болон тандалтын ажлын үр дүнг нийтийн хүртээл болгох, тоо	Гадаад болон дотоодын хэвлэлд өгүүлэл нийтлүүлсэн.	2024 онд хийгдсэн тандалт болон судалгааны ажлын үр дүнгээр өгүүлэл хэвлүүлэх төлөвлөгөөтэй байна.	Улсын төсөв, I-IV улирал	
	Гүйцэтгэсэн дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээ	Залруулсан үл тохирол, хувь	Өнгөрсөн жилийн төлөвлөгөөний дагуу дотоод аудитад хамрагдаж, илэрсэн үл тохирлыг залруулж ажиллав.	Лабораторийн үйл ажиллагаа, техникийн чадавхийг ISO17025-д нийцүүлж, дотоод аудитын төлөвлөгөөний дагуу хамрагдахаар бэлэн байдлыг хангаж ажиллаж байна.		
	Оношлуур, эм урвалжийн захиалгыг төлөвлөх, холбогдох байгууллагад хүргүүлэх,	Тендерийн үнэлгээний үйл ажиллагаанд оролцох, барааг хүлээн авах, зарцуулах, тайлагнах, тоо	Оношлуур, эм урвалжийн захиалгыг төлөвлөх, холбогдох байгууллагад хүргүүлэх, тендерийн үнэлгээний үйл ажиллагаанд оролцох, барааг хүлээн авах, зарцуулах	Тендерээр нийлүүлэгдэх багаж тоног төхөөрөмж, оношлуур, эм урвалжийг хүлээн авахаар бэлтгэж байна.		
Ерөнхий чиг үүргийн нэр: Мэдлэг чадвараа дээшлүүлэх						

Үндсэн чиг үүргийн нэр: Өөрийн мэдлэг, мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх					
ЗХГА-МЭЕГ-ын бодлого, чиглэл Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн журам	Мэдлэг, ур чадвараа ахиулах	Гадаад, дотоодын сургалтанд хамрагдах, тоо	Гадаад, дотоодын сургалтад хамрагдсан. Нийт 5	Онош зүйчдийн зөвлөлөөс зохион байгуулж байгаа дотоодын сургалтад тухай бүр оролцож байна. 2024 онд 5 хүн гадаад сургалтад хамрагдсан байна.	Улсын төсөв, I-IV улирал
	Туршлага, мэдлэг солилцох	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	БНСУ-ын Вонкванг их сургуультай хамтран хэрэгжүүлж буй “Олон улсын хамтын ажиллагааны үр дүн ба шувууны томуу өвчний судалгаа” төсөл	Дараах төслийг хэрэгжүүлж байна. Үүнд: -БНСУ-ын Вонкванг их сургуультай хамтран хэрэгжүүлж буй “Олон улсын хамтын ажиллагааны үр дүн ба шувууны томуу өвчний судалгаа” -Олон улсын цөмийн энергийн агентлагийн лабораторитай хамтарсан “Зооноз өвчний судалгаа” CRP төсөл -БНСУ-ын Амьтан, ургамлын хорио цээрийн газар болон Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн хамтарсан “Монгол улсад эргэлдэж байгаа шүлхий өвчний вирусын генетикийн шинжилгээ, судалгаа” төсөл.	Төсөл, жилд
		Хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр хурал зохион байгуулах	Тухай бүр	Нэг эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан “NATURE FOR HEALTH” (N4H-Эрүүл мэндэд ээлтэй-Байгаль) олон улсын 3 хурлыг ГХӨОТЛабораторийн хамт олон амжилттай зохион байгуулсан. Уг хуралд салбар бүрийн төлөөллүүдийг хамруулав (МЭЕГ,ХХААХҮЯ, УМЭАЦТЛ, ЭМЯ, БОАЖЯ, Зооноз өвчин судлалын үндэсний төв, Биологийн хүрээлэн ШҮА, Хустайн байгалийн цогцолборт газар, ДЭМБ суурин төлөөлөгчийн газар, WOAH, FAO, JICA, CIC).	Улсын төсөв, I-IV улирал
Ерөнхий чиг үүргийн нэр: Өсгөвөр, нуклейн хүчил, ийлдсийн хадгалалт болон хөлдөөгч хөргөгч, багаж ашиглалт сайжруулах					
Үндсэн чиг үүргийн нэр: Эерэг дээж болон нуклейн хүчлийн хадгалалт					

MNS 17025 стандарт	Нуклейн хүчлийн сан	Тоо	Нуклейн хүчлийн санд эерэг сорьц нэмсэн.	Тухай бүр бүртгэл хийгдэж байна.	Улсын төсөв, I-IV улирал	
	Эерэг дээжийн бүртгэл	Тоо	Бүртгэлийг цаг тухайд нь хийсэн.	Бүртгэлийг цаг тухайд нь хийж байна.		
Ерөнхий чиг үүргийн нэр: Архивт өгөх материал цэгцлэх бэлэн болгох, журнал хаяглах						
Үндсэн чиг үүргийн нэр:						
Архивын тухай хууль, дотоод журам	Архивт өгөх материал	Өнгөрсөн жилийн материал архивд бэлдэж өгөх	Сорьцын дагавар, экспертизын дэвтэр, тайлан зэргийг архивт бэлдэж, хүлээлгэн өгсөн.	Өнгөрсөн оны материалыг архивт өгсөн.	Улсын төсөв, I-IV улирал	
	Олон нийтийн ажилд оролцох	Зааланд бэлтгэл хийх	Мал эмнэлэгийн 100 жилийн ойд зорилусан спортын олон төрөлт тэмцээнд ГХӨТЛ-ийн бүх эмч идэвхтэй, манлайлан оролцов.	Зохион байгуулагдаж байгаа олон нийтийн ажилд тухай бүр оролцож байна.		

ЗОРИЛТ 2. МАЛ, АМЬТНЫ ХАЛДВАРТ, ПАРАЗИТТАХ ӨВЧНИЙ ОНОШИЛОГОО, ТАНДАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /үзүүлэлт/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр (сая төг), хугацаа	ТЕЗ-ын өгөх үнэлгээ
---	---------------------	------------------	--------------	-----------------	---	---------------------

Ерөнхий чиг үүргийн нэр: Мал,амьтны гоц халдварт, халдварт өвчин, хордлогыг оношлох, тандах, мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдлын баталгаажуулалт хийх					
Үндсэн чиг үүргийн нэр: Монгол орны нутаг дэвсгэр дээрх мал, амьтны халдварт, халдваргүй, хордлогот өвчнийг оношлох, онош баталгаажуулах					
1. Засгийн газрын 2008 оны 305 дугаар тогтоолын 1.4 дэх заалт, 2. МАЭМТ хууль 3. “УМЭАЦТЛ” УТҮГ-ын дүрэмд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд 4. МУЗГҮАХ 5. ЗХГА-МЭЕГ-ын бодлого, чиглэл	Арга зүй, стандарт шинэчлэх, шинээр нэвтрүүлэх	Шинэчилсэн тоо, шинээр нэвтрүүлсэн тоо	ДМАЭМБ-ын зөвлөсөн арга зүйн дагуу халдварт,паразиттах өвчнийг оношлох ийлдэс судлал,иян судлал, паразит, молекул биологи, болон бусад шинжилгээний аргын САЗ-ыг боловсруулж, батлуулан оношилгоонд хэрэглэж байна.	Нян, ийлдэс судлалын лабораторид хэрэглэж байсан хугацаа нь дууссан MNS стандартуудыг САЗ хэлбэрт оруулсан. Багаж ашиглалтын заавар (БАЗ), стандарт ажлын зааврыг (САЗ) шинэчилэн боловсруулсан.	Улсын төсөв, I-IV улирал
	Дээд байгууллагаас ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлт	-Хэрэгжилтийн үнэлгээний дундаж, хувь -Хугацаандаа гүйцэтгэсэн байдал, хоцорсон хоног	Бруцеллэз, үхрийн сүрьеэ, лейкоз өвчнийг илрүүлэх , үхрийн тархи сархиатах өвчнөөр эрүүлийг баталгаажуулах, бруцеллэзын вакцины дараах мониторинг зэрэг ажлыг зохион байгуулсан. Тайланг цаасаар болон цахимаар МЭЕГ-т хүргүүлсэн.	Бруцеллэзын халдвар илрүүлэх тандалт, бруцеллэзын вакцины дараах мониторинг, адууны 4 өвчний тандалт, Түүнчлэн Үхрийн тархи сархиатах өвчний тандан судалгаанд дээж авч шинжилгээ хийх ажлын удирдамжийг МЭЕГ-ын дарга А.Нарантуяа даргаар батлуулсан. МЭЕГ-ын даргын тушаал 2024оны 11-р сарын 21-ны Дугаар А/413 тушаалаар батлуулав.Бүх тандалтын тайланг цаасаар болон цахимаар МЭЕГ-т хүргүүлэв.	
	Шуурхай дуудлага үйлчилгээ үзүүлэх	Хэдэн удаа шуурхай дуудлагаар ажилласан, хоног	Өмнөговь аймагт 5 хоног ажилласан.	Ийлдэс судлагч С.Баярцэцэг, нян судлагчН.Ууганзаяа,Д.Ганцэцэг нар Халдварт өвчний онош тодруулах шуурхай дуудлагаар Төв аймгийн Сэргэлэн суманд 1 хоног ажиллав. Нян судлагч Н.Ууганзаяа Дорноговь аймгийн Хатанбулаг, Хөвсгөл суманд гарсан ямааны годрон өвчний голомтод 7 хоног МЭЕГ-ын удирдлага дор баг болон ажиллаж тандалт хийж халдварын бүсийг тогтоон малчидаас асуумж авч, сэжигтэй болон өвчилсөн малд задлан хийж, цусны болон эдийн	

				дээж цуглуулав. Мөн координатыг бүртгэн газар зүйн зураглал хийв.		
1. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 33.1.2, 33.1.2.2, 33.1.2.3 заалт, УИХ-ын 23 дугаар тогтоол”Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 3.3.1.4, 3.3.2.4, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.8,3 2. “УМЭАЦТЛ” УТҮГ-ын дүрэмд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын Засгийн Газрын 2018 оны 12 дугаар тогтоол, Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн 2.2.6,3.6, 3.9заалт	Тандалт шинжилгээний ажлуудын гүйцэтгэл	Тайлангийн тоо	3	3		
		Дүн шинжилгээний чанар, хувь	100%	100%		
		Хугацаандаа тайлагнасан, хувь	100%	100%		
	Вакцины дараах мониторинг, шинжилгээ	Тайлангийн тоо				
		Дүн шинжилгээний чанар, хувь	Монгол орны зүүн, баруун, төвийн бүсийн 5 аймгийн 16 сумын 225 малчин өрхийн нийт 5175 толгой охин төл малд бруцеллёзын вакцинжуулалтын мониторинг хийсэн ба дархлааны хариу урвалын түвшин 45-60 хоногийн дараах байдлаар 81.4 хувьтай байв.	Бруцеллёзын вакцины идэвхийг шалгах тандалт шинжилгээнд холбогдох хэрэглэгдэхүүн, оношлуур, үйл ажиллагааны зардлын тооцоо (50 сая 560 мянган төгрөг) хийсэн байна. Бруцеллёзын вакцинжуулалтын дараах хяналт, тандалт шинжилгээний ажил гүйцэтгэх ажлын гэрээг МЭЕГ-ын дарга А.Нарантуяа даргаар батлуулж 2024 оны 5-р сарын 13-ны өдрийн Дугаар 2024/25 тоот тушаал гарсан. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины дараах тандалтанд 2024 онд Монгол орны Зүүн, Баруун, Төвийн бүсийн 7 аймгийн 14 сумын 196 малчин өрхийн нийт 1344 толгой охин төл малд бруцеллёзын вакцинжуулалтын мониторинг хийсэн дүнгээр дархлааны хариу урвалын түвшин 45-60 хоногийн дараах байдлаар 70% -аас доош дархлааны хувьтай байна. Энэ нь дархлаажуулалтын	50,5сая МЭЕГ-ын санхүүжилтээр, III-IV улиралд	

				түвшин хангалтгүй байгааг харуулж байна.		
		Хугацаандаа тайлагнасан, хувь	МЭЕГ-т хугацаандаа хүргүүлсэн, 100 %	100%		
	Эрүүлийг баталгаажуулах тандалт шинжилгээ	Тайлангийн тоо	3	100%		
		Дүн шинжилгээний чанар, хувь	Үхрийн сүрьеэ, лейкозын тандалтаар 2021 онд 21 аймаг, нийслэлээс 2500 дээж, 2022 онд Дархан-Уул, Сэлэнгэ, Улаанбаатар, Төв, Дорнод аймгаас 1250 дээж тус тус цуглуулсан, мөн шүлхийн вакцины тандалтын 2500 дээжинд шинжилгээг хийсэн.	Үхрийн сүрьеэ болон лейкоз өвчний тандалт хийх ажлын гэрээ, хэрэглэгдэхүүн, оношлуур, үйл ажиллагааны зардлын тооцоо (174 сая 765 мянга 200төгрөг) хийж, гэрээг батлуулсан.Халдварын тандалтаар 8 аймаг(Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Төв, Дорнод, Хэнтий, Архангай, Булган), нийслэл Улаанбаатарын хотын алслагдсан дүүргийн томоохон 200-аас дээш саалийн үнээтэй дан байран маллалгаатай үхрийн фермийг сонгон ийлдсийн 1800 дээж цуглуулсан. 2024 онд улсын хэмжээнд 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотоос шүлхий өвчний вакцины дараах тандалтаар эпидемиологийн тооцоололд тулгуурлан авсан үхрийн нийт 2500 сорьц цуглуулав. Нийт 4300 дээжинд сүрьеэ, лейкоз өвчний эсрэгбием илрүүлэх Елиза урвалын шинжилгээг хийхэд бүх дээж сөрөг(-) дүн үзүүлэв.Төв болон УБ хотоос цуглуулсан184 үхрийн гепаринтэй хуруу шилэнд авсан цусны сорьцод Интерферон гамма (IFN-g)-ийг илрүүлэх сандвич ЕЛИЗА урвалын цомгоор шинжилгээ хийхэд 7үхрийн цусны сийвэнд үхрийн сүрьеэгээр эерэг дүн үзүүлэв. 26 үхрийн цусны сийвэнд шувууны сүрьеэгээр эерэг дүн үзүүлэв. Тайланг бичиж цаасаар болон цахимаар МЭЕГ-т хүргүүлэв.	174,7 сая	МЭЕГ-ын санхүүжилтээр, III-IV улиралд

			Үхрийн тархи сархиатах өвчин (ҮТСӨ): Булган, Сүхбаатар, Сэлэнгэ аймгийн мал төхөөрөх газраас тархины 180 ширхэг дээж цуглуулан, ЕЛИЗА урвалаар шинжлэв.	ҮТСӨ-ний тандалтыг 21 аймаг, нийслэлийн мах төхөөрөх газраас нийт 748 үхрийн тархины сорьц цуглуулж, шинжилгээ хийхээр төлөвлөсөн. ҮТСӨ-ний тандалтыг 21 аймаг, нийслэлийн мах комбинатад нядалгаанд орж буй үхрийн тархины 748 сорьц авч шинжилгээ хийх. Үүнээс Мал төхөөрөх үйлдвэрт суурилсан үхрийн тархи сархиатах өвчний тандалтыг 8 махны үйлдвэрээс 485 үхрийн тархины дээжийг авч шинжилгээ хийж байна. Үхрийн тархи сархиатах өвчний тандан судалгаанд дээж авч шинжилгээ хийх ажлын удирдамжийг МЭЕГ-ын дарга А.Нарантуяа даргаар батлуулсан. МЭЕГ-ын даргын тушаал 2024оны 11-р сарын 21-ны Дугаар А/413. Тайланг бичиж цаасаар болон цахимаар МЭЕГ-т хүргүүлнэ.	ҮТСЭ- 17,1сая МЭЕГ-ын Санхүүжилтээр, III-IV улиралд	
		Хугацаандаа тайлагнасан, хувь	Хугацаандаа тайлагнасан.	100%		
		Тайлангийн тоо	3 хувь	100%	МЭЕГ-ын санхүүжилтээр	

	Халдвар илрүүлэх тандалтын шинжилгээ	Дүн шинжилгээний чанар, хувь	Орон нутгийн 20 аймаг болон нийслэлийн бүх хээлтүүлэгч малд бруцеллэз өвчний халдварыг илрүүлэх тандалтын зардлын тооцоо (222сая 910 мянга 500 төг), удирдамж, гэрээг боловсруулан батлуулж удирдамжийн дагуу тандалтыг орон нутаг, нийслэлийн мал эмнэлгийн эмч нартай хамтран зохион байгуулав. Тайланг хүлээлгэн өгсөн.	Бруцеллэзын халдвар илрүүлэх тандалтанд орон нутгийн 20 аймаг, нийслэлийн бүх хээлтүүлэгч малыг хамруулах (412сая 910 мянга 510 төг) зардлын тооцоо, гэрээг боловсруулж, мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлсэн. Гэрээг батлуулсны дараа 20 аймаг, нийслэлийн МЭГ-т динамикаар хүргүүлэв. Тандалтаар нийт 20 аймгийн, нийслэлийн хээлтүүлэгч, хээлтэгч малын бруцеллэзын ийлдэс судлалын шинжилгээнд нийт 180148 сорьц шинжлэгдсэнээс илрүүлэх РБУ-аар 0,28% буюу 505 нь эерэг, ХХУ-аар 0,14% буюу 244 нь эерэг дүнтэй шинжлэгдсэн.Энэ жилийн тандалтад Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Баруун болон Зүүн тайгын Цаа буганы(Этэр) нийт 48 дээж цуглуулсан ба бүх дээж сөрөг(-)дүнтэй байв. Говь-Алтай, Говь-сүмбэр, Хэнтий аймгуудын хээлтүүлэгч малд бруцеллэзын эсрэгбием илрээгүй. Тайланг бичиж цаасаар болон цахимаар МЭЭГ-т хүргүүлэв.	МЭЭГ-ын санхүүжилтээр, III-IV улиралд /412сая 910 мянга 510 төг/	
			Адууны 4 өвчний тандалт шинжилгээг хийж аймгуудын эмч нарыг сургах	Адууны 4 өвчний тандалтын ажлыг хэрэгжүүлэх гэрээ, оношлуур, үйл ажиллагааны зардлын тооцоог (283 сая 698 мянга 500төгрөг) боловсруулсан. Адууны ям, нийлүүлэг, АХЦБӨ, адууны африк мялзан өвчний халдварлалт, тархалтыг тогтоох зорилгоор 21 аймаг, нийслэлийн 3380 адуунаас цусны сорьц цуглуулан тандалт шинжилгээ хийв. Нийлүүлгийн өвчний шинжилгээ хийгдээгүй антиген ирээгүй байна. Ям өвчний шинжилгээнд 21 аймаг, УБ хотын 6 дүүргийн 338 сумын 110 өрхийн нийт 3380 адууны ийлдсэнд	МАНЭЗЭН төсөл	

				ФХЭБУ болон ХХУ-аар шинжилгээ хийж гүйцэтгэхэд 7 сорьцод ям өвчний эсрэгбием илэрсэн. Тандалтын эерэг дүнг аймгуудаар авч үзвэл Дорноговь 0,7% (1/140), Завхан 0,4% (1/240), Увс 1,0% (2/190), Ховд 0,5% (1/170), Хэнтий 0,5% (1/180), Нийслэл 1,6% (1/60) нийт 7/980 эсрэгбием илэрч 0,7%-д эерэг дүн үзүүлсэн. ФХЭБУ, ХХУ-ын нэгдсэн дүнгээр авч үзвэл 0,2%(7/3380) нь эерэг дүнтэй байна. Бусад аймгуудаас ирүүлсэн тандалтын ийлдсэнд ФХЭБУ, ХХУ-ын шинжилгээ хийхэд адууны ям өвчний эсрэгбием илрээгүй болно.		
			“Мал төхөөрөх” үйлдвэрт суурилсан бруцеллёз, Бэтэг өвчний тандалт	“Мал төхөөрөх” үйлдвэрт суурилсан бруцеллёз, Бэтэг өвчний тандалтыг зохион байгуулах ажлын удирдамжийг МЭЕГ-ын даргын 2024 оны 8-р сарын 22-ны өдрийн А/303 тоот тушаалаар батлуулав. Бруцеллёзын тандалтад зориулж Улаанбаатар хот орчмын мал төхөөрөх 10 үйлдвэрээс (Мах импэкс ХХК, Агро нэгтгэл трейд ХХК, Саян-Уул ХХК, Мах маркет ХХК Монгол мах экспо ХХК, Оргилуун гүн ХХК, Жэй Икс Си Эс ХХК, Хүн-Од ХХК, Траст трейд ХХК, Цалуут импекс ХХК) ирүүлсэн хонь, ямаа, үхэр, сарлагын нийт 2752 сорьцод бруцеллёз өвчний тандалт шинжилгээ хийж гүйцэтгэсэн байна. УМЭАЦТЛ-д Бруцеллёзын тандалтад зориулж Улаанбаатар хот орчмын мал төхөөрөх 10 үйлдвэрээс (Мах импэкс ХХК, Агро нэгтгэл трейд ХХК, Саян-Уул ХХК, Мах маркет ХХК Монгол мах экспо ХХК, Оргилуун гүн ХХК, Жэй Икс Си Эс ХХК, Хүн-Од ХХК, Траст трейд ХХК, Цалуут импекс ХХК) ирүүлсэн хонь, ямаа, үхэр, сарлагын нийт 2752 сорьцод бруцеллёз өвчний тандалт шинжилгээ хийж гүйцэтгэсэн	МААЭЗЭН төсөл	

				байна.Тандалтаар ирүүлсэн 2752 сорьцод бруцеллэз өвчнийг илрүүлэх, оношлох зорилгоор шинжилгээг хийж гүйцэтгэхэд РБУ-аар 1.34% буюу 37 нь эерэг буюу эсрэгбием илрэв. Бруцеллэз өвчнийг оношлох зорилгоор ФХЭБУ болон ХХУ-аар шинжилгээг хийж гүйцэтгэхэд нийт сорьцын 1.12% буюу 31 нь эерэг буюу эсрэгбием илрэв. Тус 2 махны үйлдвэрийн (Траст трейд ХХК-11, Мах маркет ХХК-20) нийт 31 сорьцод эерэг дүн үзүүлэв.Тандалтын эерэг дүнг нийт сорьцтой харьцуулахад 1.12% (31/2752) нь эерэг дүн үзүүлэв.Бусад сорьцод бруцеллэзын эсрэгбием илрээгүй сөрөг(-)дүнтэй байв.		
		Хугацаандаа тайлагнасан, хувь	100%	100%		
Ерөнхий чиг үүргийн нэр: Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн чанарын удирдлагын тогтолцоог сайжруулах						
Үндсэн чиг үүргийн нэр: Мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, сургах						
Зорилт-1. МАЭМТ хууль ЗХГА-МЭЕГ-ын бодлого, чиглэл Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн журам	Оношилгооны шинэ арга, техник технологи нэвтрүүлэх	Мал, амьтны өвчний нөхцөл байдлыг харгалзан үзлэг, шинжилгээ хийж үр дүнг өгөх	Бактерийн гаралтай халдварт болон паразит өвчнийг тухай бүр оношилсон.	Халдварт, паразит өвчний оношийг молекул биологийн аргаар баталгаажуулж байна. Шинээр ямааны годрон өвчнийг нян судлалын болон молекул биологийн аргаар оношлов. Ямааны годронгийн өсгөвөр гаргаж авав.	Улсын төсөв, I-IV улирал	
	Лабораторийн бэлэн байдал хангалт	Шинжилгээнд ирүүлсэн сорьцын шинжилгээний гүйцэтгэл, хувь	Нян: Нийт 96 удаагийн хүсэлтээр 464 дээж хүлээн авч нян судлал болон молекул биологийн аргаар шинжилгээг гүйцэтгэн 640 удаа хариу гаргасан байна. Тэдгээрээс 44 шинжилгээний хариу эерэг гарсан байна.	Тайлант хугацаанд нян судлалын лабораторид 100 хандалтаар 381 дээж хүлээн авсан ба 11 үзүүлэлтээр шинжилгээг хийсэн. Өсгөвөрлөх, дурандах, биохими, хөдөлгөөн тодорхойлох, задлан, амь сорил, антибиотикийн мэдрэг чанар болон	Улсын төсөв, I-IV улирал	

			Ийлдэс: Нийт 536 удаагийн хүсэлтээр 5391 дээж хүлээн авч ийлдэс судлалын аргаар шинжилгээг гүйцэтгэсэн ба 5568 шинжилгээний хариу гаргасан байна. Тэдгээрээс 282 хариу нь эерэг дүн үзүүлсэн Паразит: Тайлант хугацаанд 68 удаагийн 939 дээж хүлээн авч ийлдэс судлал болон паразит судлалын аргаар шинжилгээг гүйцэтгэн, хариуг 1000 удаа гаргасан байна. Тэдгээрээс 584 шинжилгээний хариу эерэг дүн үзүүлсэн.	молекул биологийн аргуудаас сонгон шинжилгээг гүйцэтгэсэн. Нийт 100 удаагийн хандалтын 139 дээж эерэг гарсан. Адууны ям, боом, ДХХ, зогсоо, листериоз болон цусан халдвар, ямааны годрон өвчнийг тус тус оношилсон байна. - Ийлдэс судлалын лабораторид 475 хандалтаар нийт 2943 дээж хүлээн авсан, тэдгээрийн 941 нь ийлдэс, 216 нь арьс шир, 306 нь ангийн арьс 196 нь ноолуур, 69 хөөвөр хялгас байна. Ийлдсийн дээжинд адууны ям, бруцеллэз, иж балнад, нийлүүлгийн өвчин, үхрийн лейкоз, сүрьеэ, ямааны годрон өвчний шинжилгээг ХХУ, НУ, ЭУ, НТУ, ФХЭБУ -аар гүйцэтгэсэн. Ийлдэс судлалын шинжилгээгээр адууны ям, бруцеллэз, иж балнад болон нийлүүлгийн өвчний эсрэгбием илэрсэн байна. Нийт 427 дээж эерэг дүн үзүүлсэн. Ямааны годрон өвчнийг оношлох Елиза урвалын цомогоор 30 ямааны ийлдсэнд шинжилгээг хийхэд бүгд сөрөг байв. - Паразит судлалын лабораторид 47 хандалтаар нийт 309 дээж хүлээн авсан. Тэдгээрийн 309 нь ийлдэс, 7 нь цусны дээж ба бабезиозын эсрэгбием болон цусны паразит илрүүлэх шинжилгээг хийсэн. Арьс гууждасны 2 дээж хүлээн авч хамуу, хачгийн шинжилгээг тус тус гүйцэтгэсэн. Нийт 106 сорьц эерэг дүн үзүүлсэн. Бабезиозын эсрэгбием болон хамууны хачиг илрэв. -Угаалга ариутгалын хэсэг: нян, ийлдэс судлалын шинжилгээнд зориулж нийт 16 удаа эр хониноос цус авсан. Мөн тэжээлт орчин 65л /халдварт/, МПШ 482ш, Киттароци 520ш, тубе 1760ш, хошуу 2300ш, цусны шил 16удаа, алсеверийн уусмал 16 удаа тус тус	
--	--	--	--	---	--

				ариутгасан. Бохирын ариутгалд: Хуруу шил 5180ш, штатив 400ш тус тус ариутгасан. Нийт 117 удаа халдвартай материалыг халдваргүйжүүлсэн. Элемент медикал ХХК-тай байгуулсан гэрээний дагуу аюултай хог хаягдал 34 удаа нийт 7 тонн 930 кг ачуулсан. Халад 742ш, өмд цамц 612ш, алчуур 123ш, сандлын бүрээс 63ш, ажлын хувцас 78ш, биеийн тамирын өмсгөл 192ш, тус тус угааж, индүүдсэн. Нэрмэл ус 6 тн 400л нэрсэн. Колбо 1897, дуран 993, стакан 2023, хуванцар сав 460, флоринскийн шил 380, цодонгийн сав 620, цилиндр 230, хуруу шил 5360, бөглөө 5360, хайч 260, хямсаа 286, халбага 72, уленгутын хуруу шил 512, юүлүүр 92 тус тус угааж, ариутган шинжилгээний бэлэн байдлыг хангаж ажиллав. 2024 оны 9 дүгээр сарын 25-наас эхлэн Халдваргүй өвчний лаборантийн ажлыг давхар хийж байна. ХПӨОТЛ, ГХӨОТЛ, БОШӨОТЛ, ХЭАҮШЛ-ийн шинжилгээний бэлэн байдлыг цаг алдалгүй ханган ажиллаж байна. Хүнсний нян судлалд: Физиологийн уусмал 76л тэжээлт орчин 85.3 л, шөл 954ш, хошуу 1800ш тус тус ариутгаж шинжилгээний бэлэн байдлыг хангаж ажилласан. Угаалга ариутгалд: Дуран 830ш, колбо 420ш, хуруу шил 392ш, дээжний сав 62ш тус тус угааж ариутгасан болно.		
	Итгэмжлэл, чанарын гарын авлага, нэгдсэн арга зүйгээр хангах	Орон нутгийн эмч нарт сургалт, арга зүйн зөвлөмж өгөх	MNS, САЗ-ыг оношлогоо шинжилгээнд хэрэглэж байна.	Сүлжээ 21 аймаг, нийслэлийн лабораторид шаардлагатй САЗ-г Vetshinjlgee.mn файлын архивт байршуулсан.	Улсын төсөв, I-IV улирал	

			ХПӨОТЛ Дотоод аудит хийх			
	Сүлжээ лабораторийн мэргэжилтний чадавхжуулалт (журмын 5.1.1)	Дадлагажуулсан шинжээч, тоо	21 аймгийн МЭЛ-ийн эмч нарт бактер судлалын онолын суурь мэдлэг, шимэгч судлалын онолын суурь мэдлэг олгох сургалтыг 2 удаа зохион байгуулав. Давхардсан тоогоор 500 эмч хамрагдсан байна. Нян судлагч эмч Л.Баасанбилэгт Сүхбаатар, Дархан, Ховд, Төв аймгийн нян судлагч эмч нарт 7 хоногийн ажлын байрны дадлагажих сургалт явуулсан. Сүхбаатар Ховд, Сэлэнгэ, Дархан-Уул, Дорнод, Төв, Говь-Алтай аймгийн МЭ-ийн лабораторийн 15 малын их эмч нарт нян, ийлдэс, паразит судлалын сургалтын төлөвлөгөө гаргаж, 7-14 хоногийн сургалтыг тус тус хийв. Зах, зээл ба бэлчээрийн хөгжил нэмэлт санхүүжилт төсөлтэй хамтран ажиллах гэрээт ажлын хүрээнд Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгуудын сумын тархвар зүйч, хувийн хэвшлийн эмч нарын төлөөлөл 90 малын эмч нарт паразит өвчний гаралт тархалт оношлогооны талаархи мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалт хийв.	-Сүлжээ лабораторийн шинжлэгч эмч нарын онолын болон практик дадлагыг сайжруулах ажлын хүрээнд Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Сэлэнгэ, Хэнтий, Дорноговь аймгийн МЭ-ийн лабораторийн 15 малын их эмч нарт нян, ийлдэс, паразит судлалын сургалтын төлөвлөгөө гаргаж, 5-7 хоногийн сургалтыг тус тус хийв. - Сүлжээ 21 аймаг, нийслэлийн лабораторийн 58 эмчтэй цахим хурал хийж, дотоод хяналтын сорилын үр дүнг танилцуулсан. - Онош зүйчдийн зөвлөлөөс боловсруулсан төлөвлөгөөний дагуу ийлдэс, нян судлалын эмч нар хариуцсан шинжилгээ, судалгаатай холбоотой мэдээллийг хүргэв. - Нян, ийлдэс, паразит судлалын эмч нар 21 аймаг, нийслэлийн лабораторийн 100 эмчид цахим сургалт хийсэн. Орон нутагт ажлын байрны сургалт хийх хуваарь гаргасан.	Улсын төсөв, I-IV улирал	

	Оношлуур, урвалжийн МУ-д хэрэглэх баталгаажуулалт, дүгнэлт зөвлөмж /сүлжээ лаб-д ашиглах/	Оношлуур, урвалж, тоо (журмын 5.2.13)	Нян, ийлдэс, паразит судлалын оношлогоо, баталгаажуулалт, тандалт шинжилгээнд 30-аад төрлийн оношлуур эм урвалжийг хэрэглэж байна.	ХПӨӨТЛ-ийн эмч нарын шинжилгээнд хэрэглэгдэх оношлуур, хэрэглэгдэхүүн, эм урвалж, тоног төхөөрөмжийн захиалгыг боловсруулж, танилцуулсан. 2023 оны оношлуур, эм урвалжийн зарцуулалт, үлдэгдлийн тооцоог гаргасан.	МЭЕГ-ын санхүүжилтээр, жилдээ	
	Оношилгоо, шинжилгээнд зарцуулсан хугацааны стандарт мөрдөлт (журмын 5.1.3)	Дундаж хоног Гоц халдварт, Халдварт, Халдваргүй Шимэгчтэх,	-Ийлдэс, паразит судлалын шинжилгээнд ирсэн дээжийг хийхэд 1-2 хоног, нян судлалын шинжилгээг хийхэд 3-5 хоног зарцуулж, үр дүнг гаргаж, хариуг олгож байна.	Өмнөх түвшинг хангаж ажиллаж байна.	Улсын төсөв, I-IV улирал	
	Баталгаажуулах шинжилгээний гүйцэтгэл	Ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн шинжилгээний гүйцэтгэл, хувь	Экспорт, импортын 599 сорьцонд халдварт өвчний шинжилгээг хийсэн.	Экспортийн зорилгоор 28 улсад мал амьтны гаралтай хагас боловсруулсан, түүхий эд бүтээгдэхүүн арьс шир, ноос, ноолуурын 26 хандалтаар 512 дээж, ангийн арьс 238 хандалтаар 283 дээж(аргаль-1,буга-35,тэх-130,угалз-74,зээр-43,)хүлээн авч асколын шинжилгээ хийхэд боомын эсрэгтөрөгч илрээгүй, сөрөг(-) дүнтэй байв. Импортоор 5 улсаас 17 хандалтаар 237 адуу орж ирсэн. Уг адуунаас цусны сорьц авч ям, нийлүүлэлт, цусны паразит өвчний шинжилгээг хийж, хариуг гаргав. 24 дээж эерэг, 213 дээж сөрөг байв.	Улсын төсөв, I-IV улирал	
		Баталгаажуулах шинжилгээнд ашигласан ахисан түвшний арга зүй, хувь (журмын 3.8)	Аймаг, нийслэлээс бруцеллёзын баталгаажуулах шинжилгээнд ирсэн 72 сорьцонд ХХУ-ын шинжилгээг хийхэд 32 сорьцонд эсрэгбием илэрсэн. 36 сорьцонд хийсэн ХХУ-ын шинжилгээгээр 5 сорьцонд нийлүүлгийн өвчний эсрэгбием илэрсэн.	Онош баталгаажуулах зорилгоор аймаг, нийслэлээс 54 хандалтаар 389 дээж хүлээн авсан ба бруцеллёз, ям, нийлүүлгийн өвчний шинжилгээг хийсэн. Шинжилгээгээр 141 дээж эерэг дүнтэй байв.	Улсын төсөв, I-IV улирал	

			Тандалт баталгаажуулах	Тандалт баталгаажуулах зорилгоор аймаг, нийслэлээс 18 хандалтаар 384 дээж хүлээн авсан ба бруцеллэз, ям, нийлүүлгийн өвчний шинжилгээг хийсэн. Шинжилгээгээр 274 дээж эерэг дүнтэй байв. 110 дээж сөрөг байв. 2024 оны Тандалт шинжилгээг ям, бруцеллэз, үхрийн сүрьеэ, лейкоз, бэтэг, үхрийн тархи сархиатах өвчнөөр нийт 15427 дээжинд Елиза болон ХХУ-ын шинжилгээг хийв.	Улсын төсөв, I-IV улирал	
		Баталгаажуулсан үр дүнгийн зөрүү, хувь (журмын 3.9)	Орон нутгаас ирсэн дээжийн баталгаажуулалтын хувь 40-50%	Халдварт өвчний оношилгоог сайжруулах зорилгоор орон нутгийн эмч нарыг чадавхжуулах сургалт хийж байна.	Улсын төсөв, I-IV улирал	
	Ур чадварын сорил (журмын 3.7)	Жилд хамрагдах тоо	ХАБУЛ-иас ур чадварын сорил 4-р сарын 14 нд нян судлалын лабораторид 23-B1218 кодтой ирсэн. Шинжилгээг хийж хариуг 5-р сарын 9 нд явуулав. Нян судлалын ур чадварын сорилтонд амжилттай оролцсон.	Нян судлалын лабораторид ХАБУЛЛ-аас ур чадварын сорил 1,4-р улиралд /24-A1420 кодтой/, A1921 кодтой хүлээн ирсэн. Шинжилгээг гүйцэтгэн хариуг хүргүүлсэн.1-р улирлын ур чадварын сорил хангалттай сайн үнэлгээ авсан.	Улсын төсөв, I-IV улирал	
	Лаборатори хоорондын харьцуулалт (журмын 3.6)	Жилд хамрагдах тоо	МЭХ болон ХАБУЛЛ, МЭЭСБУЛ лабораторитой харьцуулах	Лаборатори хоорондын харьцуулалтанд 2 удаа оролцов.ХАБУЛЛ-аас нян судлалд 1, 4-р улиралд ур чадварын сорил ирсэн. Эмч нар амжилттай оролцсон.		
	Мал эмнэлгийн газрын мал эмнэлгийн лабораторид хийсэн үнэлгээ (журмын 5.1.9)		21 аймгийн МЭЛ-ийн ХПОТӨ-ний оношлогооны чадавхийг шинэчилсэн загвараар үнэлнэ. -Нян судлал (стандарт, арга зүй, тэжээлт орчин, багаж, шил сав) -Серологи (стандарт, арга зүй, тэжээлт орчин, багаж, шил сав) -Шимэгчтэх (стандарт, арга зүй, тэжээлт орчин, багаж, шил сав)			

			-Омгийн сан, нуклейн хүчлийн сан (бүртгэл, хадгалалт, ашиглалт) -Орон нутгийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, тохижсон байдал.			
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: Байгууллагын дотоод ажлын хүрээнд</i>						
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Оношлогоо, шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэх, шинэ санаачлага гаргах</i>						
Зорилт-1.	Өгүүлэл, гадаад хэл дээр	Оношилгоо шинжилгээ болон тандалтын ажлын үр дүнг нийтийн хүртээл болгох, тоо	Нян судлал: Оношлох эрдэм дэвшилт арга 16-р бага хуралд өгүүлэл бичиж хэвлүүлсэн. Паразит судлал: Оношлох эрдэм дэвшилт арга 16-р бага хуралд өгүүлэл бичиж хэвлүүлсэн.	Оношлох эрдэм дэвшилт арга онол үйлдвэрийн бага хуралд 6-н оношилгоо, шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлж байна.	Улсын төсөв, I-IV улирал	
	Оношлогооны бэлэн байдлыг хангах	Хэрэглэгдэхүүн, оношлуур, праймер захиалах бэлэн байдлыг хангах, тоо	Захиалгыг хүлээн авах, хэрэглэж тайлагнана.	Хэрэглэгдэхүүн, оношлуур, ям өвчний оношилгоонд шаардлагатай праймерын захиалга хийв.	Улсын төсөв, I-IV улирал	
	Гүйцэтгэсэн дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээ	Залруулсан үл тохирол, хувь	2023 онд Итгэмжлэлд амжилттай орох, 2-оос доошгүй удаа дотоод аудитын шалгалтад орно.	MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу үнэлгээ хийлгүүлсэн ба 9 дахь удаагаа итгэмжлэгдэв. 21 аймаг нийслэлийн мал эмнэлгийн лабораториудад нян судлал, Ийлдэс судлалын дотоод хяналтын ур чадварын сорилыг 1 болон болон 4-р улиралд явуулан үр дүнг нэгтгэн танилцуулсан ба амжилттай оролцсон аймгуудад гэрчилгээ гардуулсан.	Улсын төсөв, I-IV улирал	

	Оношлуур, эм урвалжийн захиалгыг төлөвлөх, холбогдох байгууллагад хүргүүлэх,	Тендерийн үнэлгээний үйл ажиллагаанд оролцох, барааг хүлээн авах, зарцуулах, тайлагнах, тоо	Нян, ийлдэс, паразит судлалын оношлогоо, баталгаажуулалт, тандалт шинжилгээнд 30-аад төрлийн оношлуур эм урвалжийг хэрэглэж байна.	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн оношлуур, эм урвалж хэрэглэж байна. 21 аймаг нийслэлийн МЭ-ийн лабораторид Биокомбинат ТӨХК-ний үйлдвэрлэсэн оношлуурыг хувиарлаж явуулсан.		
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: Мэдлэг чадвараа дээшлүүлэх</i>						
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Өөрийн мэдлэг, мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх</i>						
Зорилт-1.	Мэдлэг, ур чадвараа ахиулах	Гадаад, дотоодын сургалтанд хамрагдах, тоо	Нян судлал: “Мал эмнэлгийн тархварзүйн мэдлэг олгох, тархварзүйч бэлтгэх”-3 өдрийн сургалтанд хамрагдсан. “Лабораторийн амьтан судлал, шинжлэх ухааны хэрэглээ”-1 өдрийн сургалтанд хамрагдсан.	Шинжлэгч эмч Н.Ууганзаяа халдварт өвчнийг оношлох молекул биологийн чиглэлээр БНХАУ-д 14 хоногийн хугацаатай сургалтад хамрагдав. С.Баярцэцэг 2024 оны 09-р сарын 17,18 өдрүүдэд Япон улсад “Ази, Номхон далайн бүс нутгийн адууны өвчний лабораторийн оношлогоо”сэдвээр хуралдоролцов.Л.Баасанбилэгт Солонгос улсад нян судлалын чиглэлээр 10 хоног сургалтад суув. БНХАУ-ын Бруцеллёзын лавлагаа лабораторийн эрдэмтэд УМЭАЦТЛ-д ирж Оношлуур бэлэглэж ийлдэс судлалын лабораторид 3 хоногийн ажлын байрны сургалт явуулсан.	Улсын төсөв, I-IV улирал	
	Туршлага мэдлэг солилцох	Төсөл хөтөлбөрийн хүрээнд сүлжээ лабораторийн эмч нарыг сургах, суралцах, тоо	Зах, зээл ба бэлчээрийн хөгжил нэмэлт санхүүжилт төсөлтэй хамтран ажиллах гэрээт ажлын хүрээнд Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгуудийн сумын тархвар зүйч, хувийн хэвшлийн эмч нарийн төлөөлөл 90 малын эмч нарт паразит өвчний гаралт тархалт оношлогооны талаархи мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтын	Мал эмнэлгийн сүлжээ лабораториудын оношилгооны чадавхийг сайжруулах ажлын хүрээнд 21 аймаг, нийслэлийн МЭ-ийн лабораторид 3-5 хоногийн хугацаатай сургалтыг 3-4 шинжлэгч эмчийн бүрэлдэхүүнтэй баг ажилласан. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийн эрхлэгч, лабораторийн	Төсөл, 3-р улиралд	

			МЭЕГ-ын паразит өвчин хариуцсан мэргэжилтэн С.Дүүриймаа, МЭЭШХ-ийн ЭША И.Хатанбаатар, ЭШАА, Мал эмнэлгийн ухааны шинжлэх ухааны доктор, профессор Д.Болдбаатар нартай хамтран хийв.	ийлдэс судлагч, нян судлагч , шимэгч судлагч, ариун цэврийн эмч нарт ISO /IEC 17025:2018 стандартад суурилсан чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, ажлын байранд оношлогооны олон талт арга зүйг мөрдүүлэх, чанар хангалтын шаардлагуудын талаар мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх сургалт хийв. - Д.Ганцэцэг эрхлэгч Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн МЭЛ-д 9 хоногийн сургалт хийв. -- С.Баярцэцэг эмч Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн МЭЛ-д 12 хоногийн хугацаатай ажилласан. -Д.Эрдэнэжаргал эмч , Н.Ууганзаяа эмч нар Өмнөговь, Дундговь, Өвөрхангай аймгийн МЭЛ-д 9 хоногийн хугацаатай сургалт хийв. -Л Баасанбилэгт эмч Говь-Алтай, Увс, Завхан аймагт 12 хоногийн сургалт хийв.		
		Албан тушаалын тодорхойлолтын хүрээнд аймгийн лабораторийн эмч нарыг сургасан, тоо	3 аймгийн ийлдэс, паразит, өвчин хариуцсан эмчид ажлын байрны сургалт хийсэн. 4 аймгийн нян судлагч эмчид ажлын байрны сургалт хийсэн.	Сүлжээ лабораторийн шинжлэгч эмч нарын онолын болон практик дадлагыг сайжруулах ажлын хүрээнд Сүхбаатар Ховд, Сэлэнгэ, Дархан-Уул, Дорнод, Төв, Говь-Алтай аймгийн МЭ-ийн лабораторийн 15 малын их эмч нарт нян, ийлдэс, паразит судлалын сургалтын төлөвлөгөө гаргаж , 7-14 хоногийн сургалтыг тус тус хийв.		
	ArcGIS програм эзэмших	Эзэмшсэн чадвар, хувь	Оношлогдсон өвчнөөр газрын зураглал хийх Халдвар илрүүлэх тандалтаар эерэг илэрсэн өрх болон дээж цуглуулсан сум, өрхийн байршил бүхий	Хагас жилд оношлогдсон бактер, ийлдэс, шимэгчтэх өвчнүүдийн зураглалыг тархварзүйч Н.Баяртогтохоор хийлгэв.	Улсын төсөв, I-IV улирал	

			зураглал хийсэн байна. (Бүх тандалт)			
	Англи хэл сурах	TOEFL, IELTS өгсөн байдал, гүйцэтгэлийн хувь	Анхан шатны мэдлэгтэй.	Нэг эмч англи хэлний ахисан түвшний мэдлэг эзэмшиж байна.	Онлайнаар сурах, жилд	
<i>Ерөнхий чиг үүргийн нэр:</i> Өсгөвөр, нуклейн хүчил, ийлдсийн хадгалалт болон хөлдөөгч хөргөгч, багаж ашиглалт сайжруулах						
<i>Үндсэн чиг үүргийн нэр:</i> Өсгөвөрийн хадгалалт, сан бий болгох						
Зорилт-1.	Омгийн сан, ийлдсийн сан	Сорьцийн тоо	Омгийн сангийн бүрдэл хийгдсэн	Бүртгэл мэдээллийг шинэчилж хөтөлж хадгалав. Эерэг дээж, омог, өсгөврийн бүртгэл хөтлөв. Ямааны годронгийн өсгөвөр хадгалав.	Улсын төсөв, I-IV улирал	
	Нуклейн хүчлийн сан	Тоо	Нуклейн хүчлийн санд эерэг сорьц нэмсэн. Ген дараалал тогтоох шинжилгээ хийж, зүйл, гарвалыг тодорхойлно.	2024 оноос бүртгэл мэдээллийг шинэчилэн хөтөлж байна. Адууны ям өвчний үүсгэгчийг шүрэн орчинд хадгалав. Мөн ДНХ бэлтгэж, хадгалав. Гений дараалал тогтоох шинжилгээ хийж, зүйл, гарлыг тодорхойлно. Ямааны годронгийн эерэг ДНА, эдийн дээжийг хадгалав.	Улсын төсөв, I-IV улирал	
	Эерэг дээжийн бүртгэл	Тоо	Бүртгэлийг цаг тухайд нь хийсэн.	Бүртгэл мэдээллийг шинэчилсэн. Эерэг сорьцоос үүсгэгчийг ялган, коджуулан сан үүсгэнэ. Ийлдсийн эерэг дээжийг кодолж хадгалав.	Улсын төсөв, I-IV улирал	Жилдээ
<i>Ерөнхий чиг үүргийн нэр:</i> Архивт өгөх материал цэгцлэх бэлэн болгох, журнал хаяглах						
<i>Үндсэн чиг үүргийн нэр:</i> бусад ажил						

Зорилт-1.	Архивт өгөх материал	Өнгөрсөн жилийн материал архивд бэлдэж өгөх	2022 онд сорьцын дагавар, экспертизын дэвтэр, лаборатори болон тандалтын тайлан зэргийг архивт бэлдэж хүлээлгэн өгсөн.	Өнгөрсөн оны сорьцын дагавар бичиг, экспертизын дэвтэр, лаборатори болон тандалтын тайлан зэргийг архивт бэлдэж хүлээлгэн өгөв.	Улсын төсөв, I-IV улирал	
	Бусад үйл ажиллагааг зохион байгуулах, оролцох	5-аас доошгүй үйл ажиллагааг зохион байгуулсан байх	Шаардлагатай тухай бүр оролцож ирсэн.	Тайлант хугацаанд тус нэгж нь лабораторид зохион байгуулагдах дараах олон нийтийн 9 арга хэмжээг хариуцан ажиллаа. Үүнд: УМЭАЦТЛ нь Авжавын Сэр-Од агсны нэрэмжит болсонтой холбогдуулан “Дурсгалын чулуун самбарыг хүндэтгэн залах” ёслолын үйл ажиллагаа; - Цагаан сарын золголт; - Олон улсын эмэгтэйчүүдийн болон цэргийн баярын үйл ажиллагаа; - Хүүхдийн баярын үйл ажиллагаа; - Ардын хувьсгалын 103 жилийн ойн баярын арга хэмжээ; - Ахмад настны баяр тэмдэглэх; -Оношлох эрдэм дэвшилт арга 18 дахь удаагийн онол үйлдвэрлэлийн бага хурал зохион байгуулах;	I-IV улирал	

				-Байгууллагын спортын олон төрөлт тэмцээн; -Шинэ жилийн арга хэмжээ. Түүнчлэн мал эмнэлгийн салбар байгууллагуудын нөхөрсөг тэмцээнд оролцож, дэмжив. Тус нэгжийн хамт олон байгууллагын баг тамирчдаа сэтгэлийн дэмжлэг үзүүлж, өглөөний цайгаар дайлав. Тархвар зүйч нь гар бөмбөг, сагсан бөмбөгийн багт орж, амжилттай дүн үзүүлэв.		
--	--	--	--	---	--	--

ЗОРИЛТ 5. ХҮНСНИЙ ЭРҮҮЛ АХУЙ ҮЛДЭГДЛИЙН ШИНЖИЛГЭЭ, ТАНДАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /үзүүлэлт/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр (сая төг), хугацаа	ТЕЗ-ын өгөх үнэлгээ
<i>Ерөнхий чиг үүргийн нэр:</i> Байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил үйлчилгээ, тусгай захиалгат ажил үйлчилгээ						
<i>Үндсэн чиг үүргийн нэр:</i> Мал, амьтны гаралтай экспорт, импортын түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын баталгаа гаргах, төсөв бүрдүүлэх						
Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль	Мал, амьтны гаралтай экспорт, импорт, дотоодын түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлд ариун цэвэр, нян судлал, үлдэгдэл, мөөгөнцөр, цацрагийн шинжилгээ хийж, баталгаажуулах	Шинжилгээнд ирүүлсэн сорьцын шинжилгээний гүйцэтгэл, хувь 5000-аас доошгүй мал, амьтны гаралтай экспорт, импортын түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлд аюулгүйн шинжилгээ хийж, баталгаажуулах,	Дээжийн тоо 2020 онд 3905 2021 онд 4180 2022 онд 4291 2023 онд 7263	Нийт 7090 сорьцонд мал эмнэлгийн ариун цэвэр, магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу гүйцэтгэж, үр дүнг хариуны системээр хүлээлгэн өгөв. Нийт 6 (дотоод хяналт 3, магадлах 1, экспорт 2) удаагийн хандалтын 15 сорьцонд хийсэн 35 шинжилгээний дүн эерэг (мэдрэхүй, механик хольц, пероксидази болон өвчтэй ба үхсэн малын махыг ялгах формалины урвал) байна.	Улсын төсвөөр, жилдээ	
			Дээжийн тоо 2020 онд 4038 2021 онд 4243 2022 онд 4612	Нийт 7272 сорьцонд нян судлалын шинжилгээг стандарт арга зүйн дагуу гүйцэтгэж, үр дүнг хариуны системээр хүлээлгэн өгөв. Нийт 28 удаагийн хандалтын 45 сорьцонд хийсэн	Улсын төсвөөр, жилдээ	

		дүнг холбогдох газар хүргүүлнэ.	2023 онд 7533	шинжилгээний дүн эерэг гарсан байна, тэдгээрийн 43 -д нянгийн ерөнхий тоо хэвийн хэмжээнээс их, 2-д <i>E.coli</i> нянгийн тоо стандартын шаардлагад нийцээгүй байна.		
			Дээжийн тоо 2020 онд 3415 2021 онд 3423 2022 онд 3465 2023 онд 6373	Нийт 6080 сорьцонд үлдэгдлийн шинжилгээг стандарт арга зүйн дагуу гүйцэтгэж, үр дүнг хариуны системээр хүлээлгэн өгөв. Экспортын зорилгоор шинжилгээнд хамрагдсан 1 сорьц, дотоод хяналтын 2 сорьцонд хлорамфеникол, стрептомицин тус тус илэрч, эерэг дүн үзүүлэв.	Улсын төсвөөр, жилдээ	
			Дээжийн тоо 2020 онд 30 2021 онд 26 2022 онд 151 2023 онд 108	Нийт 73 сорьцонд мөөгөнцрийн болон микотоксины бохирдлын шинжилгээг стандарт арга зүйн дагуу гүйцэтгэж, үр дүнг хариуны системээр хүлээлгэн өгөв. Шинжилгээнд хамрагдсан 4 сорьцонд Цахлай өвчний үүсгэгч, Кладоспориум, мукор төрлийн мөөгөнцөр илрэв. Мөн мөөгөнцрийг таньж, тодорхойлох болон бичил мөөгөнцөр ялгах үзүүлэлтээр тус тус эерэг гарсан.	Улсын төсвөөр, жилдээ	
			Дээжийн тоо 2020 онд 3196 2021 онд 3325 2022 онд 2978 2023 онд 6116	Нийт 5942 сорьцонд цацрагийн бохирдлын шинжилгээг стандарт арга зүйн дагуу гүйцэтгэж, үр дүнг хариуны системээр хүлээлгэн өгөв. Эерэг сорьц илрээгүй байна.	Улсын төсвөөр, жилдээ	
Үндсэн чиг үүргийн нэр: Мал эмнэлгийн сүлжээ лабораториудын оношлогооны чадавхийг сайжруулах, орон нутгийн эмч нарын ур чадварыг дээшлүүлэх						
МАЭМТ хууль, МЭСЛ-ийн журмын 5.1.1	Сүлжээ лабораторийн эмч, мэргэжилтний чадавхижуулалт	Дадлагажуулсан эмч,мэргэжилтний тоо	2023 онд 8 аймаг, нийслэлийн лабораториудаас 11 эмч, мэргэжилтэн 5-10 хоногын хугацаатай мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээ, нян судлал, үлдэгдлийн лабораторийн шинжилгээний чиглэлээр арга зүй эзэмшиж дадлагажив.	МЭС-ын мал эмнэлгийн ангийн төгсөх курсын 1, МААБС-ын 3-р курсын 3 оюутанд хүнсний нян судлал, ариун цэвэр магадлан шинжилгээ, эмийн үлдэгдлийн шинжилгээний тус тус аргазүйг 10 хоногийн хугацаанд сурган дадлагажуулав.	УМЭАЦТЛ-ийн төсвөөр, жилдээ	

МАЭМТ хууль, МЭСЛ-ийн журмын 5.1.1, Малын эмийн үлдэгдлийн үндэсний хөтөлбөр МЭСЛ-ийн журмын 5.1.1	Сүлжээ лабораторийн эмч, мэргэжилтний чадавхижуулалт	Хамрагдсан эмч, мэргэжилтний тоо	2023 онд 3 удаагийн онлайн сургалт явуулсан ба давхардсан тоогоор 60 малын эмч, мэргэжилтэн хамрагдсан. .	Орон нутаг, аймгийн лабораторийн эмч нарт цахим сургалтыг оношзүйчдийн зөвлөлтэй хамтран 2 удаа зохион байгуулав. Уг сургалтаар хүнсний нян судлал, мал эмнэлэг ариун цэвэр магадлан шинжилгээ, үлдэгдлийн шинжилгээ, цацрагийн шинжилгээний арга зүйн талаар мэдээлэл хийгдсэн ба давхардсан тоогоор 40 гаруй малын эмч, мэргэжилтэн хамрагдсан.	МЭЕГ-ийн төсвөөр, жилдээ	
МАЭМТ хууль, МЭСЛ-ийн журмын 5.1.1 “Малын эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.4-р заалт МУ-ын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 78.4-р заалт 2022-2025 он хүртэлх “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө”, Эрүүл мэндийн сайд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаал А/225, А/137-р тушаал	Сүлжээ лабораторийн эмч, мэргэжилтний чадавхижуулалт	Хамрагдсан эмч, мэргэжилтний тоо	2023 онд бичил биетний тэсвэржилтийг илрүүлэх AST шинжилгээ, үлдэгдлийн шинжилгээний арга зүй эзэмшүүлэх ажлын байрны сургалтыг бүсчлэх байдлаар 4 удаа явуулсан ба 21 аймгийн нян судлагч, ариун цэврийн нийт 42 эмч, мэргэжилтэн хамрагдав.	МАН-н ЭЗЭН төслийн хүрээнд Увс, Ховд, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Дархан, Сэлэнгэ, Төв аймгийн мал эмнэлгийн лабораторийн малын эмч, мэргэжилтнүүдэд эмийн үлдэгдлийн болон хүнсний нян судлал, ББТ-ийн сургалтыг явуулав.	УМЭАЦТЛ болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр	
Үндсэн чиг үүргийн нэр: Шинжилгээний бэлэн байдлыг хангах						
“УМЭАЦТЛ” УТҮГ-ын дүрэмд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд	Шинжилгээний бэлэн байдлыг хангах	Захиалга, зарцуулалтын баримт бичиг	Лабораторийн оношлогоо, шинжилгээ хэвийн үргэжилж байгаа	2024 оны оношлуур, цомог, тэжээлт орчин, эм урвалж, тоног, төхөөрөмжийн захиалгыг боловсруулж өгөв.	МЭЕГ-ийн төсвөөр, жилдээ	
				Хүнсний нян судлалын болон мөөгөнцрийн шинжилгээнд зориулж 22 нэр төрлийн 409.6 л		

				хатуу болон шингэн тэжээлт орчин, 544.3 л физиологийн уусмал бэлтгэн, ариутгуулсан байна. ББТ-ийн шинжилгээнд зориулж 56.8 л хатуу тэжээлт орчин, 4.8 л шингэн тэжээлт орчин болон уусмал бэлтгэж, ариутгуулав.		
Үндсэн чиг үүргийн нэр: Амьтны гаралтай бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдлыг хангах, экспорт, импортонд олон улсын тавьж буй шаардлагад нийцүүлэх						
“Малын эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.4-р заалт МУ-ын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 78.4-р заалт 2022-2025 он хүртэлх “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө”, Эрүүл мэндийн сайд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаал А/225, А/137-р тушаал	Үндэсний хөтөлбөрийн төслийг баяжуулан, эх хувийг эцсийн байдлаар бэлэн болгох.	Дүн шинжилгээний чанар, хугацаандаа тайлагнасан, хувь Батлагдсан малын эмийн үлдэгдлийн хөтөлбөрийн дагуу малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд 3-аас доошгүй бүлгийн малын эмийн үлдэгдэл, 5-аас доошгүй нэрийн пестицидийн үлдэгдлийг 200-аас доошгүй дээжинд хийж, дүн, тайлагнах	2022 онд 282 дээжинд 3 бүлгийн антибиотикийн үлдэгдэл, 42 богийн өлөнд 5 бүлгийн антибиотикийн үлдэгдэл 2023 онд 21 аймаг, нийслэлийн нийт 1095 махны дээжинд 3 бүлгийн антибиотикийн үлдэгдэл, 8 богийн өлөнд 5 бүлгийн антибиотикийн үлдэгдэл	Малын эмийн үлдэгдлийн 2024 оны тандалтанд шаардлагатай урвалж, оношлуур, хэрэглэгдэхүүний захиалгыг техникийн тодорхойлолтын хамт гарган өгөв. - Импортын бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээ хийх тандалтаар 250 дээжинд бета-лактамын, тетрациклиний, сульфонамидын бүлгийн эмийн үлдэгдлийг тандахад дээрх дээжинд ҮДХ-аас хэтэрсэн үлдэгдэл илрээгүй. - 2024 оны тандалтанд аймаг, нийслэлийн гарал үүсэлтэй 192 дээжинд үлдэгдлийн 16 үзүүлэлт нийт 3072 нэгж шинжилгээг давхар масс спектрометртэй УӨМШХ (UPLC/MS/MS) болон ӨМШХ -ийн аргаар гүйцэтгэв.	МЭЕГ-ийн төсвөөр, жилдээ	
		ЕХ-ны комисст лабораторийн асуулга хүргүүлэх	1	Үлдэгдлийн хяналтын төлөвлөгөөний 2023 оны биелэлт шинжилгээний дүн, лабораторийн мэдээллийг ЕХ-ны комисст асуулгад бэлтгэн ХХААХҮЯ-ны ТНБД-ын А/432 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт танилцуулав.	УМЭАЦТЛ-ийн төсвөөр, жилдээ	
		Үлдэгдлийн шинжилгээний MNS стандарт батлагдсан байна.	1	Антибиотикийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээний 1 стандартын төслийг боловсруулав. Х.Дэлгэр ISO/TC34/SC6 WG28 малын эмийн болон пестицидийн үлдэгдлийн шинжилгээний	УМЭАЦТЛ-ийн төсвөөр, жилдээ	

				Олон улсын стандартын байгуулгын ажлын хэсэгт орж ажиллаж байна.		
Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль “УМЭАЦТЛ” УТҮГ-ын дүрэмд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд	Итгэмжлэгдсэн лабораторийн шаардлага ISO 17025:2018 стандартын шалгуурыг хангана.	ISO 17025:2018 стандартын Итгэмжлэлийг сунгуулах ажлын бэлтгэл ажлыг хангана.	ХЭАҮШЛ-ийн нян судлал, мал эмнэлэг ариун цэвэр магадлан шинжилгээ, үлдэгдлийн шинжилгээ, цацрагийн шинжилгээ, мөөгөнцрийн шинжилгээний лабораториуд 2020 оны итгэмжлэлд амжилттай оролцож, 4 жилээр итгэмжлэлээ сунгуулж байв.	ХЭАҮШЛ-ийн нян судлал, мал эмнэлэг ариун цэвэр магадлан шинжилгээ, үлдэгдлийн шинжилгээ, цацрагийн шинжилгээ, мөөгөнцрийн шинжилгээний лабораториуд итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтын дагуу болон шинээр итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтыг өргөтгөсөн хүрээгээр итгэмжлэлийн үнэлгээнд амжилттай үнэлэгдэв. Итгэмжлэлийг 4 жилээр сунгуулав.	УМЭАЦТЛ-ийн төсвөөр, жилдээ	
	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн “Залуу мэргэжилтэн хөтөлбөр”	Дадлагажигч ажилтан бэлтгэх		Төслөөс сонгогдсон дадлагажигч ажилтан Наранчимэгийг үлдэгдлийн шинжилгээнд 1 жил дадлагажуулж байна. Радио рецептор болон иммунохроматографийн шинжилгээний арга зүй эзэмшүүлэв. ӨМШХ болон ЕЛИЗА аргыг эзэмшүүлж байна.	Төслийн санхүүжилтээр	
	НҮБ, ХХААБ, АСТ төсөл	ББТ-ийн шинжилгээ	2023 онд ББТ тандалт, шинжилгээг УБ хотын ойролцоох мал төхөөрөх 3газраас 100 үхрийн олгой гэдэсний агуулагдахуунаас E.coli илрүүлж ББТ-ийг тодорхойлох шинжилгээг гүйцэтгэн шинжилгээний хариу, тайланг төслийн багт хугацаанд нь хүргүүлсэн.	2024 оны ББТ тандалт, шинжилгээг УБ хотын ойролцоох мал төхөөрөх газраас 112 үхрийн олгой гэдэсний агуулагдахуунаас E.coli илрүүлж ББТ-ийг тодорхойлох шинжилгээг гүйцэтгэн шинжилгээний хариу, тайланг төслийн баг, МЭЕГ-т хугацаанд нь хүргүүлэв.	Төслийн санхүүжилтээр	
	НҮБ, ХХААБ	Дотоодын зах зээлд борлуулагдаж буй мах, сүүний эрсдэлийн үнэлгээ, аюулгүй байдал	2023 онд дотоодын зах зээлд борлуулагдаж буй мах, сүүний 70 орчим дээжинд шинжилгээ хийж, эрсдлийг тодорхойлов.	Дотоодын зах зээлд борлуулагдаж буй махны 100, сүүний 50 дээжинд эрсдлийн үнэлгээ хийх зорилгоор микробиологи, эмийн үлдэгдлийн шинжилгээ хийж байна.	Төслийн санхүүжилтээр	

“Малын эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөр “УМЭАЦТЛ” УТҮГ-ын дүрэмд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд ЗХГА-МЭЭГ-ын бодлого, чиглэл	Гадаад, дотоодын ур чадварын сорил, лаборатори хоорондын харьцуулалтад оролцож, шинжилгээний үнэн зөв найдвартай байдлыг хангах	Оролцсон олон улсын болон дотоодын ур чадварын сорил болон лаборатори хоорондын харьцуулалтын тоо	2023 онд Гадаад ур чадварын 2, дотоод ур чадварын 3, лаборатори хоорондын харьцуулалтад 2 удаа хамрагдав.	Гадаад ур чадварын сорилд хүнсний нян судлалын лаборатори Тайландын Чулалонгкорны их сургуулын AMR-ын бүсийн лавлагаа лабораториос ББТ-ийн 2024 оны ур чадварын сорилд оролцохоор хүсэлтээ илгээсэн ба сорилын материал удахгүй ирэхээр төлөвлөгдсөн. Үлдэгдлийн шинжилгээгээр Тайландын Мал аж ахуйн бүтээгдэхүүний чанарын хяналтын газрын Мал эмнэлгийн нийтийн эрүүл мэндийн лабораторийн Үлдэгдэл шинжилгээний хэсэг (АСЕАН-ы мал эмнэлгийн эмийн үлдэгдлийн хүнсний лавлагаа лаборатори)-ээс зохион байгуулж буй ур чадварын тестэд хлорамфениколын баталгаажуулах шинжилгээгээр оролцож, “ХАНГАЛТТАЙ” үнэлэгдэв. Хүнсний нян судлалын лаборатори ХАБҮЛЛ-оос ирүүлсэн 2024 оны 1-р ээлжийн <i>E.coli</i> 0157 илрүүлэх сорил, мөөгөнцөр судлалын лаборатори <i>P.rubens</i> –ийг тодорхойлох, тоог тогтоох сорилыг тус тус аргагүйн дагуу гүйцэтгэв, Хангалттай үнэлгээ авсан болно. Хүнсний нян судлалын лаборатори ХАБҮЛЛ-оос ирүүлсэн 2024 оны 2-р ээлжийн <i>B.cereus</i> илрүүлэх, Мөөгөнцөр судлалын лаборатори <i>Aspergillus.brasiliensis</i> илрүүлэх сорилын материалыг хүлээж аван шинжилгээ хийж байна. Хариу хараахан гараагүй байна. Цацрагийн лаборатори нь Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораторид олон улсын ур чадварын сорилд хамрагдахаар хүлээн авсан цацраг идэвхит усны сорьцоор лаборатори хоорондын харьцуулалтад орсон. Цези -137 изотопыг шинжилсэн дүн нь олон улсын ур чадварын сорилын шинжилгээний хариутай таарсан. Мал эмнэлгийн ариун цэвэр магадлан шинжилгээний лаборатори Мал эмнэлгийн хүрээлэнгийн ариун цэврийн лабораторитой мал амьтны төрөл тодорхойлох харьцуулсан	УМЭАЦТЛ болон төсөл хөтөлбөрийн төсвөөр, жилдээ	
--	--	--	--	--	--	--

				шинжилгээ хийсэн, 2 лабораторийн шинжилгээний хариу таарсан болно.		
	Лаборатори хоорондын харьцуулалтын ур чадварын сорилд оролцож, шинжилгээний үнэн зөв найдвартай байдлыг хангах	Сүлжээ лабораторын дотоод ур чадварын сорил	2023 онд 21 аймаг, нийслэлийн хүнсний нян судлал болон ариун цэврийн лабораториудад хүнсний нян судлал, үлдэгдлийн ур чадварын туршилтын сорил явуулав.	2024 онд 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораториудад хүнсний нян судлал, үлдэгдлийн ур чадварын сорилын материалыг бэлтгэн явуулав.	УМЭАЦТЛ-ийн төсвөөр, жилдээ	
	Шинжилгээ, судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгоно.	Эрдэм шинжилгээний өгүүллэг болон илтгэлийн тоо	2023 онд 4 өгүүллэг нийтлүүлж, 3 илтгэл хэлэлцүүлсэн.	ХАБҮҮЛЛ-аас зохион байгуулсан Стандарт ба хүнсний аюулгүй байдал "Эрдэм шинжилгээний хурал-2024" онол үйлдвэрлэлийн бага хуралд Химич Х.Дэлгэр “Үлдэгдлийн хяналт”, “Эмийн үлдэгдлийг баталгаажуулах шинэ аргыг нэвтрүүлэв” сэдэвт 2 өгүүллэг хэлэлцүүлэн 2-р байр, Хүнсний нян судлагч Ц.Оюундэлгэр “Стандарт ба хүнсний аюулгүй байдал” ЭШБХ -ын номонд 2 өгүүлэл нийтлүүлж, шилдэг 8-д шалгарав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан “Хүнсний аюулгүй байдал–Хүнсээр хангагдах эрхийн хэрэгжилт” сэдвийн хүрээнд Химич Х.Дэлгэр “Малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал” өгүүлэг хэлэлцүүлэн 3-р байр эзлэв. Оношлох эрдэм дэвшил арга ОУБХ-д “Дотоодын зах зээлд худалдаалагдаж буй мах, сүүний эрсдлийн үнэлгээ” , “Бичил биетний тэсвэржилтийн тандан, судалгаа” “Гаммаспектрометрийн аргын баталгаажуулалтын дүн” сэдэвт өгүүлэл, илтгэл хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.	Улсын төсөв, хагас жилд	

	Давхар масс спектрометртэй УӨМШХ (UPLC/MS/MS) аргыг үлдэгдлийн баталгаажуулах шинжилгээнд нэвтрүүлэх	УМЭАЦТЛ шинжилгээнд шинээр нэвтрүүлсэн арга зүйн тоо	1	Давхар масс спектрометртэй УӨМШХ (UPLC/MS/MS)-ийн шинжилгээний аргаар үлдэгдлийн лабораторийн итгэмжлэлийн хүрээг эмийн болон пестицидийн үзүүлэлтээр өргөтгөв.	УМЭАЦТЛ, төсөл хөтөлбөрийн төсвөөр, жилдээ	
				Олон улсын атомын энергийн агентлаг /ОУАЭА/-ийн МОН 5025 “Ноолуурын ямааны удам зүйн шинжийг сайжруулах үржлийн стратеги боловсруулах” төслийн хүрээнд 79,593.2 еврогийн өртөгтэй давхар масс спектрометртэй УӨМШХ (UPLC/MS/MS)-ийн дагалдах хэрэгсэл болон лабораторийн хэрэглэгдэхүүнийг хүлээн авахаар гаалийн болон татвараас чөлөөлүүлэх ажлыг гүйцэтгэж байна.	УМЭАЦТЛ, төсөл хөтөлбөрийн төсвөөр, жилдээ	
	Оношилгоо, шинжилгээнд шинээр арга зүй нэвтрүүлэх	Сүлжээ лабораторид нэвтрүүлсэн арга зүйн тоо	1	Бүх аймаг, нийслэлийн МЭЛ-д авермектиний үлдэгдлийг тодорхойлох ФХЭБУ-ыг нэвтрүүлэх зорилгын хүрээнд Оношзүйчдийн зөвлөлтэй хамтран “Авермиктиний бүлгийн эмийн үлдэгдэл тодорхойлох ФХЭБУ” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулав. Уг сургалтад аймгийн мал эмнэлгийн лабораторийн 40 гаруй эмч, мэргэжилтнүүд хамрагдав.	МЭЕГ-ын төсвөөр, жилдээ	
		ББТ-ийн шинжилгээнд МІС-г тодорхойлох агараар шингэлэх арга зүйг шинээр нэвтрүүлэх	AST шинжилгээний диск диффузын аргын САЗ боловсруулж шинжилгээнд ашиглан нутагшуулав.	AST шинжилгээний МІС-г тодорхойлох, шингэлэх арга зүйн САЗ-ыг боловсруулж байна.	УМЭАЦТЛ-ийн төсвөөр, жилдээ	
“Малын эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөр	Олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	ОУАЭА-ийн RAS 5096 төслийг үргэжлүүлэн хэрэгжүүлэх	2022 онд 20 нэрийн үлдэгдлийн стандарт бодис, 2 нэрийн органик уусгагч хүлээн авав. 2023 онд 300 сая төгрөгний шаардлагатай стандарт бодис, хэрэглэгдэхүүн, багаж тоног төхөөрөмжийг захиалан, НӨАТ болон гаалийн	Төслийн хүрээнд зохион байгуулсан “Шинжилгээний багажийн шалгалт тохируулга, засвар үйлчилгээ, үндсэн алдааг олж засварлах тухай (Virtual Training on Analytical Instrument Calibration, Maintenance and Basic Trouble Shooting)” 5 өдрийн онлайн сургалтад 3-н мэргэжилтэн хамрагдав. Төслийн 2023 оны үйл ажиллагааны тайланг ЦЭКАА-нд тайлагнав. Катар улсад зохион байгуулагдсан “Хүнсний бүтээгдэхүүн дэх	ОУАЭА-ийн төсвөөр, жилдээ	

			татварын чөлөөлөлт хийлгэн хүлээн авав. Уг захиалгын хүрээнд нийлүүлэгдсэн багаж, тоног төхөөрөмжийг байршуулан суурилуулав	малын үлдэгдлийг баталгаажуулах аргачлалын ахисан түвшний (EVT2306370) сургалт”-д тус лабораторийн үлдэгдэл судлагч Б.Энхдөлгөөн, БНХАУ-ын Шямэнь хотод 2024 оны 8-р сарын 14-нөөс 16-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Ур чадварын тестийн үр дүн, лаборатори хоорондын хамтын ажиллагааны бүсийн уулзалт”-д тус лабораторийн химич Х.Дэлгэр, 2024 оны 8-р сарын 19-нөөс 23-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Олон төрлийн хүнсний бүтээгдэхүүний аюулын хяналт/тандалтын хөтөлбөр”-д ерөнхий эмч Ш.Мөнхдүүрэн нар оролцов.		
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: Мэдлэг чадвараа дээшлүүлэх</i>						
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Өөрийн мэдлэг, мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх</i>						
	Олон улсын хурал, сургалтанд хамрагдах	Мэргэшүүлэх сургалтанд хамрагдах	2023 онд ХЭАҮШЛ-ийн үлдэгдэл судлагч, химич Х.Дэлгэр Хоккайдо их сургуульд (UPLC/MS/MS)-ийн сургалтанд 2 сар, Филиппины Кюзрн хотод зохион байгуулсан Эрсдэлд суурилсан хүнсэн дэх үлдэгдлийн хяналт сургалтад 5 өдөр хамрагдав. ХЭАҮШЛ-ийн эрхлэгч Ё.Батнасан Японы мал эмнэлгийн холбооноос зохион байгуулсан 1 жилийн мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдав. Ц.Оюундэлгэр Тайландын Чулалонгкорны их сургуулийн AMR-ын бүсийн лавлагаа лабораторит AST шинжилгээний 3 өдрийн практик сургалтанд хамрагдав.	Химич Х.Дэлгэр ОУАЭА-ын “Цөмийн изотопын техник ашиглан ургамал амьтны гаралтай бүтээгдэхүүн дэх химийн бохирдуулагч болон үлдэгдэл бодисын хүнсний аюулгүй байдлын хяналтын хөтөлбөрт оролцогч талуудыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Панам улсад зохион байгуулагдсан Хүнсний бүтээгдэхүүн дэх бохирдуулагчийн тухай сургалтад хамрагдав. Лабораторийн эрхлэгч Ё.Батнасан БНХАУ-ын Чунцинг хотод зохион байгуулагдсан “Бичил биетний тэсвэржилтийг бууруулах замаар МАА-н тогтвортой хөгжлийг хангах нь” сэдэвт олон улсын симпозиум, Японы Жайка олон улсын байгууллагаас зохион байгуулсан “Хүнсний аюулгүй байдлын удирдлага, тогтолцоо” сэдэвт сургалт, Японы мал эмнэлгийн холбооноос зохион байгуулж Тайландын Чулалонгкорний их сургуульд болсон “Мал аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх оновчтой шийдлүүд” сэдэвт сургалт төгсөгчдийн симпозиумд тус тус оролцож илтгэл тавив.	ОУ-ын байгууллагын төсөл хөтөлбөр, хагас жилд	

	Гадаад, дотоод хурал, семинарт сургалтад хамрагдах	хамрагдсан сургалтын тоо	10	Төслийн хүрээнд зохион байгуулсан “Шинжилгээний багажийн шалгалт тохируулга, засвар үйлчилгээ, үндсэн алдааг олж засварлах тухай (Virtual training on Analytical Instrument Calibration, Maintenance and Basic Trouble Shooting)” 5 өдрийн онлайн сургалтанд 3-н эмч, мэргэжилтэн хамрагдав. Цацраг судлагч О.Чимэдцэрэн “Хүнсний бүтээгдэхүүнийг цацрагаар ариутгах технологийн асуудлууд” сэдэвт семинарт оролцов. Монголын цацрагийн хамгаалалтын нийгэмлэгээс бэлтгэн явуулдаг “Рентген шинжилгээний багаж ашиглалт, цацрагийн хамгаалалт” сэдэвт 2 өдрийн онлайн сургалтанд хамрагдан шалгалтаа амжилттай өгсөн.	УМЭАЦТЛ, төсөл, хөтөлбөрийн төсвөөр	
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: Байгууллагын дотоод ажлын хүрээнд</i>						
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Оношлогоо, шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэх, шинэ санаачлага гаргах</i>						
	Олон улс болон дотоодын хуралд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх, илтгэл тавих	Хэвлэж нийтлүүлсэн өгүүлэг, хэлэлцүүлсэн илтгэлийн тоо	Жил болгон Оношлох эрдэм дэвшилт арга ОУБХ-д өгүүлэл нийтлүүлж оролцдог.	Химич Х.Дэлгэр ХАБҮҮЛЛ-иос зохион байгуулсан Стандарт ба хүнсний аюулгүй байдал "Эрдэм шинжилгээний хурал-2024" онол үйлдвэрлэлийн бага хуралд “Үлдэгдлийн хяналт”, “Эмийн үлдэгдлийг баталгаажуулах шинэ аргыг нэвтрүүлэв” 2 өгүүлэл хэлэлцүүлэн 2-р байр эзлэв. Хүнсний нян судлагч Ц.Оюундэлгэр “Стандарт ба хүнсний аюулгүй байдал” ЭШБХ -ын номонд 2 өгүүлэл нийтлүүлж, шилдэг 8- д шалгарав. УМЭАЦТЛ-ын "Онол үйлдвэрлэлийн бага хурал-2024"-д цацраг судлагч О.Чимэдцэрэн “Гаммаспектрометрийн аргийн аргын баталгаажуулалтын дүнгээс” сэдэвт өгүүлэл , хүнсний нян судлагч Ч.Эрдэнэцэцэг “Дотоодын зах зээлд худалдаалагдаж буй мах, сүүний эрсдэлийн үнэлгээ”, Ё.Батнасан “ББТ-ийг тандан судласан ажлын дүн”сэдэвт илтгэл хэлэлцүүлэв.		

				Химич Х.Дэлгэр “Хүнсний аюулгүй байдал–Хүнсээр хангагдах эрхийн хэрэгжилт” сэдвийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хурлын их танхимд зохион байгуулагдах хуралд “Малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал” өгүүллэг хэлэлцүүлэн 3-р байр эзлэв.		
	Нийтийг хамарсан, олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох	Оролцсон олон нийтийн ажиллагааны цар хүрээ, тоо.	2023 онд Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” санаачилгын хүрээнд СХД-т 61 гарамд тасаг, лабораториороо идэвхтэй оролцож мод тарив. МҮЭХ-ноос зохион байгуулсан “Үнийн өсөлтийн эсрэг” тайван жагсаалд 11 ажилчдын хамтаар оролцов.	УМЭАЦТЛ-ийн үйлдвэрчний хорооноос зохион байгуулсан бүжгийн сургалтад амжилттай оролцов.		
	Нийтийн тэмдэглэлт өдөр, баяр, наадамд оролцох		2023 онд улсын баяр наадмаар хүй 7 худагт байгууллагаа сурталчилав. Мөн ахмадын баярт тасаг, лабораториороо идэвхтэй оролцов.	ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр зохион байгуулагдсан зураг зурах үйл ажиллагаанд хамт олноороо идэвхтэй оролцов.		

ЗОРИЛТ 6. САНХҮҮ АЖ АХУЙН НЭГЖИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /үзүүлэлт/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр (сая төг), хугацаа	ТЕЗ үнэлгээ
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: Мал,амьтны гоц халдварт, халдварт өвчний үед био-аюулгүй байдал болон бэлэн байдлыг хангаж ажиллах</i>						
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Био-аюулгүйн 3-р зэрэглэлийн лаборатори болон хөдөлгөөнт лабораторийн бэлэн байдлыг хангах</i>						
1. “УМЭАЦТЛ” дотоод журам 2. “УМЭАЦТЛ” УТУГ-ын дүрэмд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын Засгийн Газрын 2018 оны 12 дугаар тогтоол, Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн 2.2.6,3.6, 3.9 заалт	BSL-III зэрэглэлийн болон хөдөлгөөнт лабораторийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаж ажиллах	Малын гоц халдварт өвчний үед найдвартай хэвийн бэлэн байдлыг хангах	BSL-III байрлах автоклавын цахилгааны кабелийг шинээр татаж монтажилсан. BSL-III лабораторийн удирдлагын программын талаар Энлайет” ХХК-тай зөвлөлдөх уулзалт хийсэн.	Дэлхийн банкны санхүүжилтын хүрээнд ЭНЛАЙТ ХХК нь BSL-III лабораторийн агааржуулалтын ситемийг автомат удирдлагын системд холбосон, урсгал засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж ажиллав. Био-аюулгүйн 3-р зэрэглэлийн лабораторит шинээр “БАК” 3 – г суулгаж ашиглалтад оруулав. Хөдөлгөөнт лабораторит давхар гоц халдварт өвчний шинжилгээг хийх нөхцлийг хангаж ажиллав. Мөн УМЭАЦТЛ-ийн инженер техникч, цахилгаанчин нарыг BSL-III лабораторийг ажиллуулах, хэвийн үйл ажиллагааг хангах, сөрөг даралтыг шалгах, сүлжээний программыг ашиглах талаар сургалтад хамруулав.	Улсын төсөв, I-IV улирал	

	Хөдөлгөөнт лабораторийн бэлэн байдлыг хангаж ажиллах	Малын гоц халдварт өвчний үед найдвартай хэвийн бэлэн байдлыг хангах	BSL III лабораторид температур мэдрэгчийг байрлуулсан. Мөн гүн хөлдөөгч эвдэрч засвар авах боломжгүй тул аваарын хаалгаар гаргаж шинэ хөлдөөгч оруулж, тохируулга хийж хэвийн ажиллагаанд оруулсан. BSL III лабораторийн цэвэр усны шугамын хэвийн ажиллагааг хангах зорилгоор хуванцар хоолойг зэс хоолойгоор сольсон.	Хөдөлгөөнт лабораторид орж ажиллах тухай бүр агааржуулалтын ситемийн хэвийн үйл ажиллагаа, хяналтын параметруудад хяналт тавин ажиллав. Лабораторийн аюулгүй байдлын ажиллагаанд лабораторийн инженер, ХАБАЭ хариуцсан мэргэжилтэн, хяналтын чанарын менежер хяналт тавин ажиллаж байна. Ямар нэгэн техникийн доголдолгүй хэвийн үйл ажиллагаа явагдаж байна.	Улсын төсөв, I-IV улирал	
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: УМЭАЦТЛ-ийн хэмжээнд ажиллаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах</i>						
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ Мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, сургах</i>						
	Лабораторийн хэмжээнд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд урсгал засвар үйлчилгээг төлөвлөж ажиллах, бэлэн байдлыг хангаж ажиллах	Лабораторийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа хангагдсанаар лабораторийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдана.	Лабораторийн эвдэрсэн болон ажиллагааны явцад доголдсон тоног төхөөрөмжийг шалган, оношийг тогтоон шаардагдах сэлбэг хэрэгслийг захиалан, засвар үйлчилгээг хийв. Давхардсан тоогоор нийт 20 орчим тоног төхөөрөмжид 43 удаагийн засвар үйлчилгээг хийсэн. Мөн шинээр хүлээн авсан тоног төхөөрөмжийн угсралт, холболтыг хийж гүйцэтгэв.	Лабораторийн тоног төхөөрөмжийн засварыг сар бүрээр төлөвлөн ажиллаж байна. Тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааны бэлэн байдлыг хангаж ажиллахын тулд 7 хоногт 1 удаа лаборатори бүрээр явж, үзлэг хийж байна. Хагас жилийн хугацаанд 3 лабораторийн (ГХӨӨТЛ, ХПӨӨТЛ, ХЭАҮШЛ) нийт 20 тоног төхөөрөмжийн гэмтэл, доголдлыг арилгаж шаардлагатай сэлбэг хэрэгслийг захиалж, угсарч ажиллагаанд оруулав.	Улсын төсөв, I-IV улирал	

Зорилт-1.	Тоног төхөөрөмжийн ашиглалтын судалгааг үргэлжлүүлэх	УМЭАЦТЛ-ийн хэмжээнд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн тоог тодорхой болгох	Тухай бүр тоног төхөөрөмжийг засаж, хариуцагчид хүлээлгэн өгч бүртгэлийг хөтлөв.	Гоц халдварт өвчний оношилгоо тандалтын лаборатори, BSL 3 -д шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг болон багаж хэрэгслийн жагсаалтыг боловсруулан лабораторийн эрхлэгч А.Улаанхүү, ерөнхий эмч Ш.Мөнхдүүрэн нарт танилцуулсан. Тоног төхөөрөмжийн техникийн бичиг баримтыг бүрдүүлэх, бүртгэлийг сайжруулах, тогтмолжуулах зэрэг ажлуудыг хийсэн.	Улсын төсөв, улирал I	
-----------	--	--	--	---	-----------------------	--

	Шаардлагатай сэлбэг хэрэгслийн захиалгыг жилийн өмнөөс хийж удирдлагад танилцуулан шийдвэрлүүлж бэлэн байдлыг хангах	Засвар үйлчилгээ хийгдсэн тоног төхөөрөмжийн тоонд үндэслэх	Дараах материалыг шинээр суурилуулан хэвийн үйл ажиллагааг хангав. Үүнд: -Угаалгын машин -Узелийн өрөөний халаалтын насос -Байгууллагын ариун цэврийн өрөөний суултуурын уян хоолой -Хийн баллоны редуктор (БОШӨӨТЛ) -Хийн шланк, муфть, тройник - Вакуум насосны тос (Үлдэгдэл)	Тайлант хугацаанд дараах байдлаар бэлэн байдлыг хангаж ажиллав. Үүнд: -Хоёр ламинар боксны дээш доош гүйдэг хаалганы тросс тасарсныг сольж, хэвийн болгов. -Үлдэгдлийн лабораторид бойлер суурилуулж, халуун ус ашиглах боломжтой болгов. -Тахианы өндөг хадгалах инкубатор худалдан авч, тохируулан хэвийн ажиллагааг хангав. -Байгаль орчны лабораторийн холигч хугарсан учраас шинээр захиалж, суурилуулсан. Дээрх үйл ажиллагаатай холбоотой холбогдох санхүүгийн баримтыг тухай бүр танилцуулав.	Улсын төсөв, улирал II	
--	---	--	---	---	--------------------------------------	--

	Техник , тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалт болон засвар үйлчилгээний талаарх баримт бичгийг хөтлөх	Баримт бичгийн хөтлөлтийг үндэслэх	Дараах бүртгэлийг хөтөлдөг. Үүнд: -Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний бүртгэл -Тоног төхөөрөмжийн засварын талаарх нэгдсэн бүртгэл -Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүртгэл 4. Шингэн азотын хяналтын бүртгэл 5. Хөдөлгөөнт лабораторийн ашиглалт, засвар үйлчилгээний бүртгэл	Лабораторийн хэмжээнд ашиглаж байгаа хийн баллоны судалгаа гаргаж бүртгэлжүүлэх шаардлагын хүрээнд техникийн бичиг баримтыг бүрдүүлэх, бүртгэлийг сайжруулах ажлуудыг хийсэн.	Улсын төсөв, I-IV улирал	
Ерөнхий чиг үүргийн нэр: Санхүү						
Үндсэн чиг үүргийн нэр:						
ТБОНӨТ хуулийн 70, 72, 73 зүйл, ТТХ хууль, НББТ хууль	2024 оны эд хөрөнгийн тооллогын комисс томилуулан хагас, бүтэн жилийн тооллого явуулах, ашиглагдахгүй болсон, техник эд хогшлыг ТӨХ болон байгууллагын техник, үнийн комиссын шийдвэрийг үндэслэн засварлан ашиглах, актлах, устгах	Хууль тогтоомжинд нийцүүлнэ		УМЭАЦТЛ-ийн Захирлын А/87 дугаар тушаалаар “2024 оны жилийн эцсийн тооллогын комисс томилох тухай” жилийн эцсийн тооллогын ажлын хэсэг томилогдсон. Байгууллагын үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг тоолох комиссын ажлын хэсгийн хамт жилийн эцсийн тооллогыг комиссын дарга Ц.Урангоо удирдлага дор чанартай үр дүнтэй гүйцэтгэж ӨХБЗ-д	Улсын төсөв, I-IV улирал	

				танилцуулсан. “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн №2024/1 хурлын шийдвэрийг үндэслэн актлах, дахин үнэлэх үндсэн хөрөнгийн жагсаалтыг дээд шатны байгууллага “Мал эмнэлгийн ерөнхий газар”-т хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн 2023 оны 12 дугаар сарын 13, 26 өдрийн 837, 687-р тогтоолын хэрэгжилтийг 67 тоот албан бичгээр ТӨБЗГ, МЭЕГ-т хандсан. ТӨБЗГ-ын 2024 оны 01 дүгээр сарын 25 өдрийн А-1/178 тоот албан бичгийн дагуу МЭЕГ-т бүртгэлтэй Суудлын авто машин Лада улсын дугаартай 3617 УНЭ, арлын ХТА213100L0211667 дугаартай авто машиныг Балансаас балансад шилжүүлэн авсан. Umch.sgov.mn “Төрийн өмчийн тооллогын систем”д Байгууллаагын өмч хөрөнгийг санхүүгийн балансын дагуу нэг бүрчлэн тайлагнаж цаг хугацаанд нь баталгаажуулж ажилласан байна. 2024 оны жилийн эцсийн тооллогыг УМЭАЦТЛ-ийн захирлын А/87 тушаалаар томилодсон ажлын хэсэг тооллогыг хийж дуусгасан, тайлан нэгтгэгдэж 12 дугаар сарын 15 – нд эцэслэн танилцуулна.		
--	--	--	--	---	--	--

ТТХ хууль, НББТ хууль	Төрийн сантай харилцаж байгууллагын санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, мөнгөн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээ хийх, сар бүрийн төсвийн гүйцэтгэл, НДШ-ийн тайлан боловсруулж хянуулах, сар бүр шинжилгээний орлогын тооцооны тулгалт хийж бүртгэх	Хууль тогтоомжинд нийцүүлнэ	Төрийн сантай харилцаж, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ хийх, сар бүрийн төсвийн гүйцэтгэл, НДШ-ийн тайлан боловсруулж хянуулах, шинжилгээний орлогын тооцооны тулгалт хийх зэргээр байгууллагын санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангаж, ажиллав.	Энэ оны 12-р сарын жилийн эцсийн байдлаар, үндсэн үйл ажиллагааны орлого 552.9 сая төгрөгөөр бүрдүүлж ажиллахаас 697.4 сая төгрөг төвлөрүүлж 144.5 сая төгрөг давуулан биелүүлж байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ирсэн. 2024 оны 12дугаар сарын 05 өдрийн Сангийн сайдын №224 дугаар давсан орлого 59,213,083.00 төгрөгийг зарцуулах тушаал гарсан. Сангийн сайдын 272 дугаар тушаалыг үнэслэн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 35,530,850.00 төгрөг, өр, төлбөр, эмч мэргэжилтэн нарт нэн тулгамдсан компьютер, принтерийн асуудлыг шийдвэрлэхэд 23,687,233.00 төгрөгийг зарцуулахаар Захирлын А/87 тоот тушаалын дагуу хууль, дүрэмд нийцүүлэн олгосон. Улсаас авсан санхүүжилт 1,617.8 сая төгрөгийн санхүүжилт улсаас авч байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж ирсэн. Үүнээс цалин хөдөлмөрийн хөлсөнд 1,323.37 сая төгрөг, АО-с нийгмийн даатгалын шимтгэлд 159.6 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 101.66 сая төгрөг, хангамж бараа материалын материал 33.84 сая төгрөг, эм, эмнэлгийн хэрэгсэл 19.35 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 242.5 сая төгрөг, дотоод албан томилолт 20.59 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ 121.166 сая төгрөг, бараа материалын бусад зардал 1.7 сая төгрөг, харуул хамгаалалтын зардал 11.73, лабораторийн лабораторийн итгэмжлэл 5.4 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	Улсын төсөв, I-IV улирал	
-----------------------	---	-----------------------------	--	--	--------------------------	--

			17.8 сая төгрөг, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 140.3 сая төгрөг, Малын архаг халдварт өвчнөөс 23.29 зарцуулж байгууллагын үндсэн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаж ажилласан. Нэмэлт санхүүжилт 1,574.4 сая төгрөгийн санхүүжилт төвлөрсөн. Энэхүү санхүүжилтээр БНСУ-ын “Монгол улсад эргэлдэж буй шүлхийн үүсгэгчийн судалгаа” 100.3 төгрөг, БНСУ-ын “Шувууны томуу” төсөл 68,16 сая төгрөг, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ Дугаар: УМЭАЦТЛ 2023/02 12.3 сая төгрөг, Япон улсын Амьтны эрүүл мэндийн үндэсний институт хамтарсан шүлхий зэрэг хил дамнасан мал, амьтны гоц халдварт өвчний вирус ялгах судалгааны ажлын санхүүжилт 8.4 сая төгрөг, ХХААХҮЯ-ны сайдын А/479 тоот тушаалыг үндэслэн 9 тандалтын санхүүжилт болох 1,310.07 сая төгрөгийг 21 аймаг, нийслэлтэй хамтар зохион байгуулж дууссан. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, сарын мэдээг баталгаажуулах, НДШ-ийн тайланг сар бүрийн 05- ны дотор хянан баталгаажуулах, өдөр бүр шинжилгээний орлогын тооцооны тулгалт хийж санхүүгийн тайланд бүртгэх, авлага, өглөгийг тооцоолж байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлж ажилласан. 2024 оны 01 дүгээр сарын 03 өдөр батласан худалдан авах төлөвлөгөөний дагуу нийт 395.543.300.0 төсөвт өртөгтэй “Мал, амьтны гоц халдварт халдварт,	
--	--	--	---	--

				халдваргүй өвчин, хүнсний аюулгүй байдлын баталгааг хангах зарим үзүүлэлтийг тодорхойлох оношлуур, хэрэглэгдэхүүн худалдан авах тендерийн баримт бичиг” худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. УМЭАЦТЛ/20240102001 тендерийн урилгын дугаартай ХХА-аар нийт 70 нэр төрлийн барааг худалдан авч тандалтад ашиглаж байна.		
ТТХ хууль, НББТ хууль	2025 оны төсвийн төсөл боловсруулан Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ХХААХҮЯ-нд хүргүүлэх.	Хууль тогтоомжинд нийцүүлнэ	2024 оны төсвийн төсөл боловсруулан Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.	2025 оны төсвийн төслийг боловсруулахаар байгууллагын нэгж тасаг бүрээс санал авч захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр ажиллаж байна.	Улсын төсөв, I-IV улирал	
ТТХ хууль,	Сар, улирал, жилийн санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд нь гаргаж, үр дүнг тухайн жилийн төсөвтэй уялдуулан ХХААХҮЯ, СЯ, Төрийн санд тайлагнах, аудитын хяналт шалгалтанд үнэн зөв мэдээллээр хангах, Шилэн дансны тайлан мэдээ тухай бүр нь тайлагнаж мэдээллэх	Хууль тогтоомжинд нийцүүлэх	Сар, улирал, жилийн санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд нь гаргаж, үр дүнг тухайн жилийн төсөвтэй уялдуулан ХХААХҮЯ, СЯ, Төрийн санд тайлагнасан. Аудитын хяналт шалгалтанд хамрагдаж, үнэн зөв мэдээллээр хангасан. Шилэн дансны тайлан мэдээ тухай бүр нь тайлагнаж мэдээллэж ажилласан.	Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, нийгмийн даатгалын тайлан, албан хаагчдын цалин, хөлснөөс суутгасан орлогын албан татварын тайлан, шилэн дансны мэдээг цаг хугацаанд нь мэдээлсэн, мөн төрийн өмчийн тооллогын системд (umch.sgov.mn) тухай бүр нь тайлагнаж харьяалах дээд шатны төрийн захиргааны байгууллагын цахим системд тайлагнаж баталгаажуулсан. Монгол улсын үндсэн хууль, төсвийн тухай хууль, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн дагуу шилэн дансны мэдээллийг тухай бүр хөтөлж ил тодоор тайлагнасан. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар	Улсын төсөв , I-IV улирал	

				болгосон төсөвт байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар санхүүгийн аудитын хяналт, шалгалт хийж 2024 оны 02 дугаар сарын 29- ны өдрийн 07/520 дугаартай “өөрчлөлтгүй санал дүгнэлт” аудитын гэрчилгээг хүлээн авсан.		
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт</i>						
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Хүний нөөцийн чиглэлээр</i>						
Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авилгын эсрэг хууль	“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Авилгын эсрэг хууль”-ийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх	Хууль тогтоомжинд нийцүүлэх	Хууль, журамд заасны дагуу ХАСХОМ мэдүүлэх 11 албан тушаалтны мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан, АТГ-т хүргүүлж, хянуулсан.	Санхүү, аж ахуй, үйлчилгээний нэгжийн даргаар томилогдсон Л.Алтансүхийн ХАСХОМ-ын мэдээллийг АТГ-т хүргүүлсэн ба ашиг сонирхлын зөрчил үүсээгүй тул 02-р сарын 20-ны өдрөөс албан тушаалд томилсон. Л.Алтансүх өөрийн хүсэлтээр ажлас чөлөөлөгдсөн бөгөөд, одоогоор захиргааны нэгжийн даргын орон тоо сул хэвээр байна.	Улсын төсөв, жилд	

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг, холбогдох хууль, шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилт	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах	Холбогдох тогтоомжинд нийцүүлэх	Хууль	Мал эмнэлгийн лабораторийн эмч, ажилчдын цалингийн сүлжээг өөрчлөх саналыг хүргүүлсэн.	Засгийн газрын 84, 128 дугаар тогтоолын дагуу Захирлын А/23 дугаар тушаалаар албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт орсон ба мэдээллийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим системд байршуулав. Мөн албан хаагчдын мэдээллийг тухай бүр тогтмол шинэчлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын багц хуульд өөрчлөлт, шинэчлэлт орсонтой холбогдуулан даатгуулагчийн төрлийн код, ажил мэргэжлийн кодыг Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим системд нэг бүрчлэн шинэчлэн оруулж, санхүүтэй тулгалт хийж баталгаажуулав. Төв лабораторийн удирдлага болон хүний нөөцийн мэргэжилтэн М.Ренчинмядаг миний бие 2022 оноос хойш 21 аймаг орон нутгийн лабораторийн эмч, ажилчдыг тусад нь ангилал зэрэглэл, сүлжээтэй болгох ажил биеллээ олж 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэн дэмжигдэж, 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдаж, төв лаборатори болон 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийн эмч, ажилчдын цалинг “Төрийн үйчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-д багтаж тусдаа цалингийн зэрэглэлтэй болсон. Байгууллагын боловсон хүчинтэй болон үйл ажиллагаатай холбоотой 89 тушаал боловсруулан батлуулжээ. Хувь хүнээс 14, ахмад эмч, албан хаагчаас 56 өргөдөл, нийт 70 өргөдөл хүлээн авч, бүртгэлд	Улсын төсөв, жилд
---	--	---------------------------------	-------	--	---	-------------------

			хамруулан, удирдлагад танилцуулан (шинээр ажилд томилуулах, чөлөө хүсэх, үндсэн ажилтнаар томилуулах, ажил хавсран гүйцэтгэх, хавсран гүйцэтгэсэн албан тушаалын цалингийн хувь авах, орон сууц хүсэх тухай) 47 өргөдлийг цохолтын дагуу, 23 өргөдлийг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн нийт 70 өргөдлийг шийдвэрлүүлж ажиллав. Эмч, ажилчдын гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлсэн талаарх судалгааг нэгтгэж, 2024 онд гадаад оронд мэргэжил дээшлүүлсэн албан хаагчдаар хамт олонд мэдээлэл хийх тушаалын хэрэгжилтийг хангуулах ажлыг холбогдох албан хаагчдаар гарын үсгээр баталгаажуулан хуваарийн дагуу эхний мэдээллийг албан хаагчдад танилцуулсан болно. Лаборатори, нэгжүүдээс 2024 оны ээлжийн амралтын хуваарийг авч нэгтгэн удирдлагад танилцуулан Захирлын Б/01 тушаалаар хуваарийг батлуулж, хуваарийн дагуу 44 эмч, ажилтанд ээлжийн амралтыг олгоод байна. Эмч, ажилчдын цагийн бүртгэлд хяналт тавьж, шаардлагатай үед удирдлагаас өгсөн үүргийн дагуу өрөө, лабораториудаар явж өглөө, орой давхар бүртгэл хийж ажиллав. Цагийн бүртгэлийн нэгтгэлийг сард 2 удаа гаргаж Ахлах нягтлан бодогчид өгч, цалинг олгуулах, сар бүр нэгж, лабораторийн дарга, эрхлэгч нараас ирүүлсэн албан хаагчдын ур чадварын үнэлгээг нэгтгэж, захирлын тушаалаар албажуулан санхүүд хүргүүлж ажиллав. Цагаан сарын баярыг тохиолдуулан ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа хошуучлан ажилласан 2 эмч, 7 ахмад эмч, ажилтныг	
--	--	--	---	--

			Төрийн одон медаль, “Алтан гадас” одон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны салбарын “Тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнуулахаар холбогдох материалыг бүрдүүлэн, МЭЕГ-т хүргүүлж ажилласнаас 2024 оны 03 дугаар сарын 08-ны өдөр 1 ахмад эмч, 1 ахмад ажилтан салбарын “Тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнагдсан. Мөн ХХААХҮЯ-ны 100 жилийн ойг тохиолдуулан 1 эмчийг Төрийн одон медаль “Алтан гадас” одон, 3 эмчийг Засгийн газрын шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулахаар холбогдох материалыг бүрдүүлэн ХХААХҮЯ-д хүргүүлээд байна. Тайлант хугацаанд өөрийн хүсэлтээр 10 албан хаагчийг чөлөөлж, шинээр 9 ажилтанг ажилд томилжээ. Мөн “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын заалтыг зөрчсөн албан хаагчдын асуудлыг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 2 эрхлэгчид 1 болон 2 сарын хугацаатай цалингийн 20 хувиар, 2 эмчид нээлттэй сануулах арга хэмжээг 6 сарын хугацаатай хариуцлага тооцсон.	
Ерөнхий чиг үүргийн нэр: Архивт өгөх материал цэгцлэх бэлэн болгох, журнал хаяглах				
Үндсэн чиг үүргийн нэр: бусад ажил				

Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль Албан бичиг хөтлөлтийн нийтлэг журам	Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй холбоотой ажлын төлөвлөгөө батлуулах, шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж ажиллах	Хууль, журам, удирдамжид нийцүүлэх	Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаалаар баталсан “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай” тушаал, холбогдох дүрэм, журмыг судлан байгууллагын 2024 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт (Хүний нөөц, удирдлага, санхүү, архив, бичиг хэрэг, итгэмжлэл, чанарын гарын авлага)-ыг боловсруулж, гүйцэтгэл 60 хувьтай хийгдэж байна. Холбогдох мэдээлэл, материалыг нэгж, лабораторийн дарга, эрхлэгч нарт цахимаар хүргүүлсэн болно. 2021-2022 оны өргөдөл, гомдлын мэдээг нөхөн гаргав. Байгууллагын архиваас түр ашиглуулахаар 10 хадгаламжийн нэгж, Захирлын тушаал болон шүүхийн шийдвэр, өргөдөл зэрэг 8 баримтын хуулбар олгосон байна. Захирлын 2023 оны боловсон хүчинтэй холбоотой тушаалуудыг скайнердан, цахим архив болгон Hard дискэнд хадгалав.	Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаалаар баталсан “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай” тушаал, холбогдох дүрэм, журмыг судлан байгууллагын 2024 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт (Хүний нөөц, удирдлага, санхүү, архив, бичиг хэрэг, итгэмжлэл, чанарын гарын авлага)-ыг боловсруулж, гүйцэтгэл 60 хувьтай хийгдэж байна. Холбогдох мэдээлэл, материалыг нэгж, лабораторийн дарга, эрхлэгч нарт цахимаар хүргүүлсэн болно. Нийгмийн даатгалын хуульд өөрчлөлт орж, төрийн байгууллагуудын нийгмийн даатгалын тайланг цахим системд оруулахтай холбогдуулан албан хаагчдын тушаал шийдвэрийг скайнердаж ахлах нягтлан бодогчид өгөв. Байгууллагын архивын өрөөг зориулалт, стандартын дагуу 1 давхарт байршуулж, өрөөг сонгох, баримтыг нүүлгэн шилжүүлэх ажлыг удирдлага, нэгжийн даргад танилцуулан ажиллаж байна. Байгууллагын Баримт нягтлан шалгах арга зүйн комисс (БНШАЗК)-ын тушаалыг шинэчлэн батлуулж, комиссыг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хуралдуулж 2024, 2025 оны ХХНЖ-ыг комиссын хурлаар батлах, “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт шинэчлэгдсэнтэй холбоотой шинжилгээний хариуны хадгалах хугацааг тохирох, байгууллагын архивын баримтыг нүүлгэх асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.	Улсын төсөв, Жилдээ	
---	--	---	--	--	----------------------------	--

				Архивын анхан шатны бүртгэлүүдийг шинээр хэвлэх, баримтыг эмхлэх, хуудас дугаарлах, хавтаслах, жинлэх, хүлээн авсан тухай анхан шатны бүртгэл хөтлөх зэрэг ажлыг бие даан гүйцэтгэн 51 хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийгээд байна.		
--	--	--	--	---	--	--

Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль Албан бичиг хөтлөлтийн нийтлэг журам	Нэгж, лабораторийн албан хаагчдаас архивт баримтыг стандартын дагуу хүлээн авах, түүний чанарт хяналт тавих	Хууль тогтоомжид нийцүүлнэ.	Архивын анхан шатны бүртгэлүүдийг шинээр хэвлэх, баримтыг эмхлэх, хуудас дугаарлах, хавтаслах, жинлэх, хүлээн авсан тухай анхан шатны бүртгэл хөтлөх зэрэг ажлыг бие даан гүйцэтгэн 40 хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийгээд байна.	2024 оны архивын баримтыг хүлээн авах ажлын хүрээнд нэгж, лабораторийн эмч, ажилчдад архивын баримтын хуудсыг дугаарлах, архивын баримтыг цэгцлэх, хавтаслах талаар зөвлөгөө өгч, архивын анхан шатны бүртгэлүүдийг нэгж, лабораторийн дарга/эрхлэгч нарт цахимаар хүргүүлж ажиллав. Мөн байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийх, архивт баримт хүлээн авах хуваарийг батлуулан нэгж, лабораторийн дарга/эрхлэгч нарт хүргүүлэн ажилласнаар Нэгж, лабораториудаас 29 хадгаламжийн нэгж хүлээн авч, байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийв.	Улсын төсөв, Жилдээ	
---	--	------------------------------------	---	--	----------------------------	--

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ хууль Албан бичиг хөтлөлтийн нийтлэг журам	Тушаал, боловсруулсан бичиг	Баримт бичгийн стандарт, албан хэрэг хөтлөх журмыг мөрдөх, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг эрхлэх, анхан шатны бүртгэлийг хөтлөх, тайлагнах, тамга тэмдэг, баталгааны хэвлэмэл хуудсыг зориулалтаар нь ашиглах	Эхний хагас жилийн байдлаар харилцагч байгууллагуудаас 73 албан бичиг хүлээн авч бүртгэн захиралд танилцуулсны дагуу холбогдох эмч, ажилтнуудад өгснөөс 64 албан бичиг шийдвэрлэгджээ. Мөн А4 албан бичиг-95, А5 албан бичиг-67 харилцагч байгууллагуудад явсан байна. Захирлын 40 А/тушаал баталгаажиг гарсан ба орон нутагт ажиллах 16 хүний томилолт гарсан байна. Захирлын зөвлөлийн 13 удаагийн хурлын тэмдэглэл хөтөлж, захирлын өгсөн үүрэг даалгаврыг дарга эрхлэгч нарт файлаар өгч, биелэлтийг танилцуулж, ажиллаа.	Захиралтай уулзах хүмүүсийн цаг товлох, гадаад, дотоодын зочид төлөөлөгчид ирэхэд угтан авч холбогдох хүмүүст мэдэгдэх, уулзалтыг зохион байгуулах, уулзах, хуралдах өрөө, заал, хэрэгцээт зүйлсийг бэлтгэн, тухай бүр ирэх гадаад хүмүүст нэвтрэх зөвшөөрөл хүссэн албан бичиг дотоодын цэргийн 05 дугаар ангид хүргүүлэн хамтран ажиллаж байна. Лабораторитой хамтарч ажиллах байгууллага, хувь хүнд гэрээний драфт өгч, 43 байгууллага, хувь хүнтэй гэрээ байгуулсан байна. 2023 оны Захирлын 99 А/тушаал-2 боть, А4-явсан бичиг- 3 боть, А5-явсан бичиг -3 боть, ирсэн бичиг-3 боть тус тус архив болон цахим архивт бэлтгэв.	Улсын төсөв, I-IV улирал	
--	------------------------------------	---	---	---	---------------------------------	--

	Лабораторын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл байдлыг хангах, ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах		Тус лабораторийн ХПӨОТЛ-ийн ийлдэс судлалын лабораторийн засварын ажил, мөн лабораторийн үндсэн барилгын 4 давхрын өрөө тасалгаа мөөгөнцөртөж, архивын өрөө болон эм урвалж хадгалах агуулах шаардлага хангахгүй байгаа тул шаардлагатай засвар үйлчилгээг яаралтай хийх зорилгоор “Хүрээ хишиг од” ХХК-тай 19,807.200 гэрээ байгуулан 2024 оны 04-р сараас эхлэн засвар үйлчилгээг хийж байна.	Лабораторийн үндсэн барилгын дээврийн хар цаас зарим газраа хаван үүсч хууларсан, хагарсан, ашиглалтын хугацаа дууссан, 3,4-р давхар руу ус нэвчин гоожсон тул шаардлагатай засвар үйлчилгээг яаралтай хийх, лабораторийн хэвийн үйл ажиллагааны бэлэн байдлыг шуурхай хангахын тулд “СБ” ХХК-тай 17,500,000 төгрөгийн гэрээ байгуулан 05-р сарын 27-28 өдрүүдэд засварласан. Цацрагийн өрөөний галын аюулгүй байдлыг хангах зорилгоор галын дохиоллын систем суурьлуулсан.	Улсын төсөв, жилд	
--	---	--	---	--	-------------------	--

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Ерөнхий эмч	 /Ш.Мөнхдүүрэн/	2024.12.15.
(Албан тушаал)	(Нэр, гарын үсэг)	(Огноо)